



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 03 сарын 16-ны
өдрийн 47.49 дугаарт бүртгэв.

2020 оны 03 сарын 16 өдөр


Дугаар А/179

Улаанбаатар хот

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг
магадлан шинжлэх шалгуур батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрхийн эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуурыг нэгдүгээр, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуурыг хоёрдугаар, Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх аргачлалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллага, магадлан итгэмжлэлийн шинжээчдийг магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх арга зүйгээр ханган, сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллага, шинжээчдэд хийх сургалтын зардлыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 07 дугаар тушаалын 3, 4, 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Бүртгэлийн дугаар 26
 МОНГОЛ УЛСЫН
 ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙМ
 ХУУЛБАР ҮНЭН
 Хүү: Б.Зүе
 20 03 20
 Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 03 дугаар сарын
16. ны өдрийн 1779 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР

БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Дэд бүлэг 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Байгууллага нь тусламж, үйлчилгээ үзүүлэх үйлчлүүлэгчээ зөв таньж, үйлчилгээ үзүүлдэг тогтолцоо бүрдүүлсэн байна.	1.1.Төв нь үзлэг, оношилгоо, ажилбар, үйлдэл хийхэд үйлчлүүлэгчийг зөв таних үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан байх	1. Эрүүл мэндийн төвд хийгдэх оношилгоо, эмчилгээний ажилбар, үйлдэл хийх бүрт /эм өгөх, тарилга хийх, шинжилгээ авах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх гэх мэт/ үйлчлүүлэгчийг зөв таньж тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл явцыг тодорхойлсон баталсан журамтай 2. Үйлчлүүлэгчийг зөв таних үйл явцыг тодорхойлсон журмыг нийт ажилтнуудад танилцуулсан, мөрддөг 3. Хэрэгжилтэнд хяналт тавьдаг	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.2.Тусламж, үйлчилгээ үзүүлэх бүрт үйлчлүүлэгчийг зөв таних аргыг тодорхойлсон, хэрэглэдэг байх	1. Үзлэг, оношилгоо, эмчилгээний ажилбар хийхэд үйлчлүүлэгчийг зөв таних 2-оос доошгүй аргыг байгууллагын хэмжээнд хэрэглэхээр /өрөөний дугаар, байрлалыг оруулахгүй/ баталгаажуулсан 2. Үйлчлүүлэгчийг зөв таних аргыг ашиглах талаар эрүүл мэндийн ажилтнуудад зөвлөгөө өгдөг 3. Үзлэг, оношилгоо, эмчилгээний ажилбар, үйлдэл хийх бүрийн өмнө үйлчлүүлэгчийг таних аргыг ашиглаж хэвшсэн 4. Баримт бичгийн тэмдэглэгээ, хяналтын хуудас хөтөлдөг	5, 4, 3, 2, 0



		1.3.Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг таньж, тусламж, үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг хийсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч /харааны, сонсголын, хэл ярианы, хөдөлгөөний, сэтгэцийн, хавсарсан/-ийг таних талаар журамд тусгасан 2. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч /харааны, сонсголын, хэл ярианы, хөдөлгөөний, сэтгэцийн, хавсарсан/-д тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл явц, аргыг тодорхойлсон, хэрэгжүүлдэг 3. Ажилтанг бэлтгэж, сургасан 	5, 4, 3, 2, 0
2.	Байгууллага нь үйлчлүүлэгчтэй харилцах, холбоо тогтоох, мэдээлэл өгөх тогтолцоог бүрдүүлсэн байна.	2.1.Үйлчлүүлэгчээс амаар, утсаар мэдээлэл авах, мэдээлэл өгөх үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан, хэрэгжүүлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгчээс амаар болон утсаар мэдээлэл, /үзлэгийн захиалга/ авах, өгөх журамтай, баталгаажуулсан 2. Үйлчлүүлэгчээс амаар болон утсаар мэдээлэл авах, өгөх журмыг нийт ажилтнуудад танилцуулсан, зөвлөгөө өгдөг 3. Эмнэлгийн ажилтны үйлчлүүлэгчид утсаар болон амаар мэдээлэл өгч, авч буй үйл явцад хяналт тавьж, баримтжуулсан 	5, 4, 3, 2, 0
		2.2.Хөгжлийн бэрхшээлтэй /харааны, сонсголын, хэл ярианы/ үйлчлүүлэгчээс мэдээлэл авах, мэдээлэл өгөх үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах аргыг тодорхойлсон, ашигладаг 2. Харааны, сонсголын, ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах ажилтанг бэлтгэсэн 3. Харилцааны аргыг хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчээр өөрөөр нь сонгуулдаг 	5, 4, 3, 2, 0
3.	Үйлчлүүлэгчийн оношилгоо, шинжилгээний дүгнэлтийг бүртгэх, мэдээлэл тогтолцоотой байна.	3.1.Үйлчлүүлэгчид хийгдсэн шинжилгээний яаралтай болон аюултай /анхаарал татсан/ хариуг бүртгэх мэдээлэл, мэдээллийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлсон, мөрддөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Яаралтай шинжилгээ болон шинжилгээний аюултай /анхаарал татсан/ хариуг бүртгэх, мэдээлэл, мэдээллийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлсон журам, зураглалтай, баталгаажуулсан 2. Яаралтай шинжилгээ болон шинжилгээний аюултай /анхаарал татсан/ хариуг мэдээлэл үйл ажиллагаанд хяналт тавьдаг 	5, 4, 3, 2, 0
4.	Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг хангасан тогтолцоо бүрдүүлсэн байна.	4.1.Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм /антикоагулянт, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм/-ийн аюулгүй байдлыг хангадаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Холбогдох тушаал, шийдвэртэй уялдуулан байгууллагын хэмжээнд мөрдөх өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийг тодорхойлж, тэдгээрийн хадгалалт, жор бичилт, хэрэглээ ба хяналтын асуудлыг багтаасан журам батлуулж, хэрэгжүүлдэг 2. Эмийн өрөөнд өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ 	5, 4, 3, 2, 0

			авсан /эмийн жагсаалттай, хадгалалт, зарцуулалтын заавар, зөвлөгөө өгдөг, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт хийх г.м/ 3. Хяналтын хуудас хөтөлдөг	
		4.2.Ижил дуудагддаг, гадна байдал нь ижил харагддаг эмийн жагсаалттай, эмнэлгийн мэргэжилтнүүдэд таниулсан байх	1. Ижил дуудагддаг, гадна байдал нь ижил харагддаг эмийн жагсаалтыг гаргаж, баталгаажуулсан 2. Ижил дуудагддаг, ижил харагддаг эмийн талаар үзүүлэн, самбартай, шинэчлэн ашигладаг	5, 4, 3, 2, 0
5.	Эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч унаж, гэмтэхээс сэргийлэх арга хэмжээ авсан байна.	5.1. Төвийн гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч унаж, гэмтэх эрсдэлээс сэргийлдэг байх	1. Төвийн гадаад, дотоод орчинд тогтмол үнэлгээ хийж, үйлчлүүлэгч унах эрсдлийг тогтоодог 2. Гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч явганаас унаж, гэмтэх эрсдэл үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авдаг /зам талбайн бүрэн бүтэн байдал, хальтиргаа, гулгаа үүсэх, шат, шатны хонгил, орох хаалганы орчин, шалны материал, бариул гэх мэт/ 3. Гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч унаж, гэмтэх эрсдэл үүсэхээс сэргийлсэн анхааруулга, таних тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан 4. Анхааруулга, таних тэмдэг, тэмдэглэгээ нь үйлчлүүлэгчид ойлгомжтой, энгийн, үзэмжтэй	5, 4, 3, 2, 0
		5.2.Үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ хийж, унах эрсдэлийг тодорхойлж, гэмтэж бэртэхээс сэргийлдэг байх	1. Байгууллагын хэмжээнд үйлчлүүлэгчийн биеийн байдал, онош болон бусад нөхцөл байдалд үндэслэн унаж гэмтэх эрсдэлийг үнэлдэг шалгуурыг баталсан /таталт өгдөг эсэх, эмийн хэрэглээ, архины хэрэглээ, алхахад асуудалтай эсэх, тэнцвэрийн байдал, сэтгэцийн асуудал зэрэг/ 2. Үйлчлүүлэгчийн онцлогт тохирсон унахаас хамгаалахад шаардлагатай хэрэгслээр хангаж, ашигладаг 3. Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчийг байгууллагын бүх ажилтнууд таньж мэддэг, сэргийлэх арга хэмжээ авч, тусламж үзүүлдэг 4. Үнэлгээ болон унахаас сэргийлэх авсан арга хэмжээг баримтжуулсан	5, 4, 3, 2, 0
6.	Гэрийн дуудлагаар тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад аюулгүй байдлыг	6.1. Гэрийн дуудлагаар тусламж, үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчийг тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангасан байх	1. Гэрийн дуудлагаар тусламж, үйлчилгээ үзүүлэхэд ашигладаг автомашины аюулгүй байдалд хяналт тавьдаг 2. Автомашинд дохиолол, дуудлагын системийг байрлуулсан 3. Автомашинд техникийн үзлэг, засвар үйлчилгээ хийлгэдэг	5, 4, 3, 2, 0

	хангаж ажиллана.		4. Үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн байгууллагад аюулгүй тээвэрлэх нөхцөлийг хангасан	
Онооны дүн	Авбал зохих оноо		
	Авсан оноо		

Дэд бүлэг 2. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хянах тогтолцоог бүрдүүлсэн байна.	1.1. Төв нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байх	1. Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг зохицуулсан журамтай 2. Журмын хэрэгжилтийг хангаж, ажилладаг 3. Хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлдэг	5, 4, 3, 2, 0
		1.2.Амбулатори, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх зохион байгуулалтыг хийсэн байх	1. Амбулатори, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх зохицуулалт хийсэн 2. Амбулатори, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх хуваарийг эмч, мэргэжилтэн бүрээр гаргаж, мөрддөг 3. Хуваарийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлж байгаад тогтмол хяналт тавьж, дүгнэлт өгдөг	5, 4, 3, 2, 0
2.	Тусламж, үйлчилгээг тасралтгүй авах мэдээллээр үйлчлүүлэгчийг хангасан байна.	2.1.Тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, зохицуулалт, ачаалал, хүлээгдлийн талаар мэдээллийн самбар, цахим хуудсанд тогтмол мэдээлдэг байх	1. Төвийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, цагийн хуваарь, ачаалал, хүлээгдлийн талаарх мэдээллийг үйлчлүүлэгч авах нөхцөлийг бүрдүүлж, тогтмол мэдээлдэг 2. Мэдээллийн самбар, /цахим дэлгэц/, цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй 3. Тусламж, үйлчилгээний мэдээллийн ил тод байдлыг хангасан	5, 4, 3, 2, 0
3.	Үйлчлүүлэгчийг хүлээн авах, тусламж, үйлчилгээ үзүүлэх, хянах хүлээлцэх үйл ажиллагааг	3.1.Тусламж, үйлчилгээ авахаар ирсэн тохиолдол бүрт бүртгэл хөтөлж, авсан арга хэмжээний талаар тэмдэглэл хөтөлдөг байх	1. Үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийх бүрт холбогдох анхан шатны бүртгэлийн маягт, хяналтын хуудсыг хөтөлдөг 2. Үйлчлүүлэгчид үзүүлсэн тусламж, үйлчилгээ, өгсөн зөвлөгөөний талаар тэмдэглэл хөтөлсөн 3. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0

	зохицуулсан байна.	3.2.Тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлдэг байх	1. Жагсаалтад заасан тусламж, үйлчилгээнээс тухайн төвийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний жагсаалт, хувийг гаргах	5, 4, 3, 2, 0
		3.3.Лавлагаа шатлалын тусламжид илгээсэн үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээнд хяналт тавьдаг байх	1. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгчийг илгээх журамтай, мөрддөг 2. Тусламж, үйлчилгээнд илгээсэн үйлчлүүлэгчийн бүртгэлтэй, анхан шатны маягтыг хөтөлдөг 3. Үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эргэн мэдээлэл, хяналтыг хийдэг 4. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас өгсөн үйлчлүүлэгчид үргэлжлүүлэн хийгдэх эмчилгээ, хяналтын талаарх зөвлөмжийг хэрэгжүүлдэг 5. Лавлагаа шатлалын эмнэлэгт хэвтсэн үйлчлүүлэгчийн тоо нь эрүүл мэндийн төвийннийт бүртгэлтэй хүн амын тооны 10%-иас ихгүй байгаа	5, 4, 3, 2, 0
		3.4. Амбулаторийн карт /жирэмсний хяналтын, хүүхдийн карт/-ын хөтлөлт бүрэн байх	1. Амбулаторийн картыг стандарт, зааврын дагуу хөтөлдөг 2. Үзлэг, оношилгоо, эмчилгээний заалтыг бичдэг	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

Дэд бүлэг 3.ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Үйлчлүүлэгчийг мэдээллээр хангаж, лавлагаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг байна.	1.1.Лавлагаа мэдээллийн хөтөч/ажилтан, лавлагаа өгөх цэг ажиллуулдаг байх	1. Лавлагаа мэдээллийн хөтөч, мэдээлэл өгөх үйлчилгээний цэгийг зохион байгуулсан 2. Лавлагаа мэдээллийн хөтөч/ажилтанг сургасан 3. Үйлчлүүлэгч мэдээлэл авах булан, самбар ажиллуулдаг /цахимаар болон байршуулсан/ 4. Лавлагаа мэдээллийн цэгт үйлчилгээний багц, хөнгөлөлт, байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг ил тод байршуулсан 5. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыг байршуулсан	5, 4, 3, 2, 0

			6. Байгууллагын зохион байгуулалт, үйлчилгээний нэгж, хэсгийн чиглэлийгзаасан тэмдэг, тэмдэглэгээ нь ил тод ойлгомжтой	
		1.2.Төв нь үйлчлүүлэгчид тав тухтай орчинд тусламж, үйлчилгээ үзүүлдэг байх	1. Хүлээлгийн танхимуудад тав тухтай орчин бүрдүүлсэн 2. Үйлчилгээ авахад саад бэрхшээлгүй 3. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч, хүүхэд, өндөр настантай харилцах, үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх /ширээ, сандал, тэргэнцэр ... гэх мэт/	5, 4, 3, 2, 0
		1.3. Цаг товлох үйлчилгээ үзүүлдэг байх	1. Утсаар болон цахимаар үзлэг, оношилгооны цаг товлох захиалгыг авдаг 2. Үйлчлүүлэгчийн дараалал, цаг товлалтыг цахим болон автомат бүртгэлээр зохицуулдаг 3. Цаг товлох үйлчилгээнд өөрчлөлт гарсан тохиолдолд үйлчлүүлэгчид эргэн мэдээлж, тэмдэглэдэг	5, 4, 3, 2, 0
2.	Байгууллага нь тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөн болон тэдний гэр бүлийн эрх ашгийг хамгаалах үүрэг, хариуцлагатай ажиллана.	2.1.Үйлчлүүлэгчийн эрх, үүргийг тодорхойлж, баталгаажуулсан байх	1. Үйлчлүүлэгчийн эрх, үүргийг баталгаажуулж, хүлээлгийн танхимуудад ил байршуулсан 2. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх явцад баримтлах ёс зүйн хэм хэмжээний талаар мэдээлдэг 3. Бүх ажилтнууд үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, ёс зүйн хэм хэмжээний талаар мэдлэгтэй, үйлчлүүлэгчид тайлбарлаж чаддаг 4. Үйлчлүүлэгчид зөвлөгөөгөх, харилцааны ур чадварт эмнэлгийн мэргэжилтэнг сургасан 5. Сургалтын удирдамж, хөтөлбөртэй	5, 4, 3, 2, 0
		2.2.Үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээний явцад биеийн, хэл ярианы, соёлын болон бусад саад бэрхшээл, чирэгдэлгүй үйлчилгээ авах нөхцөлийг хангасан байх	1. Тусламж, үйлчилгээний явцад үйлчлүүлэгчид тулгарч болох биемахбодын, соёлын, хэл ярианы болон бусад саад бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэх арга хэмжээ авдаг 2. Үйлчлүүлэгчид тулгарч болох биемахбодын, соёлын, хэл ярианы болон бусад саад бэрхшээлийг шийдвэрлэх талаар ажилтныг сургасан 3. Үйлчлүүлэгчийн хувийн эд зүйлсийг хамгаалах чиглэлээр байгууллагын үүрэг, хариуцлагын мэдээллийг өгдөг 4. Үйлчлүүлэгчийн эд зүйлс алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авсан	5, 4, 3, 2, 0
3.	Үйлчлүүлэгчийн	3.1.Тусламж, үйлчилгээний	1. Үйлчлүүлэгчид хийгдэх эмчилгээ, оношилгоо, түүний үр	5, 4, 3, 2, 0

	эрхийг хүндэтгэж, тусламж, үйлчилгээний шийдвэр гаргалтад оролцуулдаг тогтолцоог бүрдүүлсэн байна.	шийдвэр гаргалтанд үйлчлүүлэгчийг оролцуулдаг байх	дүн, гарч болох эрсдлийн талаар өөрт нь болон гэр бүлийхэнд нь энгийн үгээр, ойлгомжтой тайлбарлан танилцуулдаг 2. Үйлчлүүлэгчид хийгдэх оношилгоо, шинжилгээ, эмчилгээний талаар санал солилцож, тэдний шийдвэрийг сонсож хүндэтгэдэг 3. Үйлчлүүлэгчид хийгдэх оношилгоо, эмчилгээ, ажилбар үйлдлийн үр дүн, гарч болох хүндрэл, эрсдлийн талаар өөрт нь болон гэр бүлийхэнд нь танилцуулдаг, тэмдэглэл хөтөлдөг	
		3.2.Байгууллага нь үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээтэй холбоотой мэдээллийг үнэн, зөв өгдөг байх	1. Үйлчлүүлэгчид эмчилгээ, оношилгоотой холбоотой мэдээлэл өгөх журамтай, хэрэгжүүлдэг /Хэн, хэзээ, ямар мэдээлэл өгөх үйл явц/ 2. Үйлчлүүлэгч болон гэр бүлийнхэнд үнэн, зөв дараах мэдээллийг өгдөг: • эмчилгээ, оношилгоо хийж байгаа эмнэлгийн мэргэжилтний нэр, ажлын туршлага • үйлчлүүлэгчийн биеийн байдал • эмчилгээ, ажилбар, үйлдлийн явц, үр дүн • гарч болох хүндрэлүүд гэх мэт. 3. Үйлчлүүлэгчийн гэр бүлийнхэнтэй уулзах, эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх өрөөний тав тухтай байдлыг хангасан	5, 4, 3, 2, 0
4.	Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байна.	4.1.Байгууллагын удирдлагууд үйлчлүүлэгч болон ажилтантай уулзаж, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг байх	1. Байгууллагын удирдлага үйлчлүүлэгч, ажилтантай уулзах баталсан хуваарьтай 2. Хуваарийн дагуу уулзаж, санал хүсэлтийг хүлээн авсан бүртгэлтэй 3. Шийдвэрлэсэн асуудлын тоо/хувь	5, 4, 3, 2, 0
		4.2.Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг боломжит сувгаар хүлээн авч, тухай бүр шийдвэрлэж, эргэн мэдээллэх тогтолцоотой байх	1. Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг цахим, утсаар, амаар болон бичгээр авдаг 2. Хариуцсан ажилтантай 3. Ирсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлын бүртгэлийг хөтөлдөг 4. Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийдэг 5. Хугацаанд нь шийдвэрлэж, хариу өгч, эргэн мэдээлсэн өргөдлийн тоо/хувь	5, 4, 3, 2, 0

		4.3.Байгууллага нь иргэний өргөдөл, гомдлыг судлан, эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хийдэг байх	1. Иргэний өргөдөл, гомдлыг судлан, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу хийдэг 2. Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо/хувь 3. Үйл ажиллагааны тайлантай	5, 4, 3, 2, 0
		4.4.Үйлчлүүлэгч үзлэг, оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний үр дүнд сэтгэл ханамжтай байх	1. Үйлчлүүлэгчээс авсан сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээний дүгнэлт	5, 4, 3, 2, 0
		4.5.Албан бус төлбөр, бэлэг авах, өгөх нөхцөлийг бүрдүүлэхгүй байх	1. Үйлчлүүлэгчээс авсан сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээний дүгнэлт 2. Байгууллагын дотоод журамд албан бус төлбөр, бэлэг авах, өгөхийг хориглосон, хэрэгжүүлдэг 3. Хяналт тавьдаг	5, 4, 3, 2, 0
		4.6.Байгууллага нь үзүүлж буй тусламж, үйлчилгээний талаар олон нийтэд сурталчилдаг байх	1. Цахим хуудас болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан 2. Иргэд, олон нийтэд сурталчилгаа зохион байгуулсан ажлын тайлантай	5, 4, 3, 2, 0
		4.7.Зорилтот бүлгийн иргэдийн тусгай хэрэгцээ, шаардлагыг хангасан орчинг бүрдүүлж, тусламж, үйлчилгээ үзүүлдэг байх	1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүн 2. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд /харилцааны бэрхшээлтэй иргэд/ тусламж үйлчилгээ авах орчныг бүрдүүлсэн 3. Орон гэргүй, ядуу иргэд, хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ авахад нь дэмжлэг үзүүлдэг 4. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	5, 4, 3, 2, 0
		4.8.Үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийнхэн болон эмнэлгийн мэргэжилтэнд эвлэрүүлэн зуучлах, хууль зүйн болон нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө авах нөхцлийг бүрдүүлсэн байх	1. Үйлчлүүлэгчид нийгэмсэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг 2. Нийгмийн ажилтан ажиллуулдаг 3. Нийгэм-сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн хүний бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
5.	Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах тогтолцоог бүрдүүлсэн байх	5.1.Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалдаг байх	1. Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах асуудлыг дотоод журамд тусгасан 2. Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн 3. Энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлэгчдийг сургалтанд хамруулсан 4. Баримт бичгийн нууцлал, хадгалалт, хамгаалалтад хяналт тавдаг	5, 4, 3, 2, 0

Онооны дүн	Авбал зохих оноо
	Авсан оноо

Дэд бүлэг 4. ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
а.Амбулаторийн тусламж, үйлчилгээ:				
1.	Амбулаториор үзлэг, оношилгоо, эмчилгээг хийж, зөвлөгөө өгдөг байна.	1.1.Амбулаторийн үзлэгийн өрөөнүүдийг зохион байгуулж, үзлэг, оношилгоог бүрэн хийдэг байх	1. Батлагдсан бүтцийн дагуу амбулаторийн үзлэгийн өрөөнүүдийг зохион байгуулсан 2. Үзлэг, оношилгоо, эмчилгээг стандарт, зааврын дагуу хийдэг 3. Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан 4. Үзлэгийн өрөө бүрт үйлчлүүлэгчид, зөвлөгөө өгөхөд ашиглах зурагт самбар, биет үзүүлэн /муляж/, гарын авлагатай	5, 4, 3, 2, 0
		1.2.Үзлэгийн өрөө нь батлагдсан нормативт тохирсон ачаалалтай, үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай үйлчилгээ үзүүлдэг байх	1. Үзлэгийн ачааллыг зохицуулж, үйлчлүүлэгчид товлосон цагт нь үйлчилгээ үзүүлдэг 2. Үйлчлүүлэгчийн үзлэгийн дарааллын мэдээллийг ил тод байршуулдаг 3. Үзлэг, оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавьдаг 4. Хийгдсэн үзлэг, оношилгоо, эмчилгээ, өгсөн зөвлөгөөний талаар амбулаторийн картад тэмдэглэл хөтөлдөг 5. Холбогдох анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
		1.3.Амбулаториор хийгдэх ажилбар, үйлдлийн жагсаалттай байх	1. Амбулаториор хийгдэх ажилбар, үйлдлийн жагсаалтыг баталсан 2. Ажилбар, үйлдлийг батлагдсан стандарт, удирдамж, зааврын дагуу хийдэг 3. Эмнэлгийн мэргэжилтнүүд ажилбар, үйлдлийг хийх ур чадварыг эзэмшсэн, хийдэг 4. Эмнэлгийн мэргэжилтний гардан үйлдэл гүйцэтгэж байгаа байдалд дотоод хяналт, үнэлгээ тогтмол хийж, үнэлгээний дүнгийн мөрөөр арга хэмжээ авдаг	5, 4, 3, 2, 0

	1.4. Өдрийн эмчилгээний хэсэгтэй, үйлчүүлэгчид ээлтэй, тав тухтай орчинд эмчилгээ, үйлчилгээ хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Өдрийн эмчилгээний өрөөтэй, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр хангасан 2. Хариуцсан эмнэлгийн мэргэжилтэнтэй 3. Өдрийн эмчилгээ хийхэд холбогдох журмыг мөрддөг 4. Өдрөөр хийгдэх эмчилгээ, үйлчилгээний жагсаалттай 5. Эмчийн заалтаар эмчилгээг хийж, анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлдөг 6. Эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийн бүртгэлтэй 	5, 4, 3, 2, 0
--	----------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------

Дэд бүлэг 5. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Халдварын сэргийлэлт, хяналтын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажилладаг байна.	1.1. Халдварын сэргийлэлт, хяналт /ХСХ/-ын багийг зохион байгуулсан, төлөвлөгөөтэй байх	<ol style="list-style-type: none"> 1. ХСХ-ын багийг томилсон шийдвэртэй 2. Багаар ажиллаж, асуудлаа тодорхойлж шийдвэрлэсэн 3. ХСХ-ын чиглэлээр хийх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй 4. Жил бүр хэрэгжилтийг үнэлдэг, тайлан дүгнэлттэй 5. ХСХ-ын асуудал хариуцсан эмч эсвэл сувилагчийг ажиллуулсан 6. Томилсон ажилтанд үндсэн ажлаас гадна ХСХ-ын үйл ажиллагаанд зарцуулах цагийн менежмент хийсэн 	5, 4, 3, 2, 0
		1.2. ХСХ-ын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Хяналт, үнэлгээг хуваарийн дагуу сургагдсан мэргэжилтнүүд хийсэн 2. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн цэвэрлэгээ, ариутгалд жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийдэг 3. Эмнэлгийн орчны цэвэрлэгээнд жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийдэг 4. Хог хаягдлын ангилан ялгалт, менежментэд жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийдэг 5. Хяналт, үнэлгээний дүнг ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулахад ашигладаг 6. Хяналтын төрөл, тоог олшруулсан 	5, 4, 3, 2, 0

		1.3. Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуйн байдалд хяналт, үнэлгээ хийсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Гар угаах нөхцлийг бүрдүүлсэн эсэхэд жилд 2-оос доошгүй удаа хяналт хийсэн 2. Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэгийг жилд 1-ээс доошгүй удаа үнэлсэн 3. Гарын эрүүл ахуйн сахилтын ажиглалтын үнэлгээнд тусламж, үйлчилгээнд оролцож байгаа эрүүл мэндийн ажилтныг бүрэн хамруулж, жилд 1-ээс доошгүй удаа үнэлгээ хийж, түвшин тогтоосон 4. Спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэх бүтээгдэхүүний хэрэглээ, зарцуулалтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийдэг 5. Хяналт, үнэлгээний асуумж, шалгуур үзүүлэлтийг ашигладаг 6. Хяналтын үр дүнг тооцож дүгнэлт гарган, хийх үйл ажиллагааг төлөвлөдөг 	5, 4, 3, 2, 0
		1.4. Эрүүл мэндийн ажилтанд ХСХ-ын мэдлэг олгох сургалт хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. ХСХ-ын чиглэлээр бэлтгэгдсэн, эсвэл дадлага туршлагатай мэргэжилтэн сургалт хийсэн 2. Шинэ ажилтанд ХСХ-ын чиглэлээр чиг баримжаа олгох сургалт хийсэн 3. Сургалтын хөтөлбөрт халдвараас сэргийлэх стандарт (байнгын) сэргийлэлтийн арга хэмжээ тусгагдсан 4. Сургалтын үр дүнг тооцсон, чанар сайжирсан 5. Эрүүл мэндийн ажилтан ХСХ-ын мэдлэгтэй 	5, 4, 3, 2, 0
		1.5. Эрүүл мэндийн ажилтандараах дадлыг эзэмшсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Гарын эрүүл ахуйн сургалтанд хамруулсан, зөв угааж, халдваргүйжүүлэх дадал эзэмшсэн 2. Эрүүл мэндийн ажилтанхог хаягдлыг зөв ангилсан 3. Хурц үзүүр, иртэй хэрэгсэлтэй зөв харьцдаг 4. Хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зөв хэрэглэдэг 5. Хамгаалах хувцсыг зөв өмсөж, аюулгүй тайлах дадал эзэмшсэн 	5, 4, 3, 2, 0
2.	Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчийг эмнэлгийн тусламж үйлчилгээний явцад халдварт өртөх эрсдлийг	2.1. Үйлчлүүлэгчид тарилга, арьс салст цоолох ажилбар хийхдээ аюулгүй байдлыг хангаж ажилладаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Арьс салстын бүрэн бүтэн байдлыг алдагдуулсан ажилбар бүрийн гүйцэтгэлд хяналтын хуудас ашиглан улирал бүр хяналт хийсэн 2. Алдаа, дутагдлыг илрүүлэн шалтгааныг тогтоож, арилгуулах арга хэмжээ авсан 3. Тарилга, хатгалтад ариун материал ашигладаг 4. Зөвшөөрөгдсөн антисептик уусмалаар талбайг 	5, 4, 3, 2, 0

	бууруулахад чиглэсэн ажиллагаа байна. үйл хийдэг		халдваргүйжүүлдэг 5. Найруулах уусмалын аюулгүй байдлыг хангаж ажилладаг	
		2.2.Эрүүл мэндийн ажилтанг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авдаг байх	1. Хамгаалах хувцас хэрэгслээр тасралтгүй хангадаг 2. Хамгаалах хувцас хэрэгсэл нь ажилтныг хамгаалах аюулгүй байдлын шаардлага хангасан 3. Гар угаах, халдваргүйжүүлэх бүтээгдэхүүн нь харшил, хуурайшуулах нөлөө үзүүлдэггүй 4. Харшил өгдөг, хуурайшуулж арьсанд гэмтэл өгдөг бол бүтээгдэхүүнийг өөрчлөх арга хэмжээ авсан	5, 4, 3, 2, 0
		2.3. Эрүүл мэндийн ажилтан халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн үед халдвараас сэргийлэх арга хэмжээний бэлэн байдлыг хангасан байх	1. Эрүүл мэндийн ажилтанг өртөлтийн дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээний санамж анхааруулгаар хангасан 2. Өртөлтийн дараах сэргийлэлтэд шаардагдах хэрэгслээр хангагдсан цомогтой 3. Гепатитийн В, С вирус, ХДХВ, тэмбүү илрүүлэх тестээр илрүүлэг хийх мэргэжилтэнг сургасан 4. В гепатитын дархлаажуулалтанд эрсдэлд өртсөнөөс хойш 48 цагийн дотор хамрагдах боломжтой	5, 4, 3, 2, 0
		2.4. Эрүүл мэндийн ажилтан халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдолд халдвараас сэргийлэх арга хэмжээ авсан байх	1. Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдлыг бүртгэсэн 2. Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтанг шаардлагатай шинжилгээнд зааврын дагуу хамруулсан 3. В гепатитын дархлаажуулалтад хамрагдах шаардлагатай тохиолдлыг өртөлтөөс хойш 48 цагийн дотор хамруулсан	5, 4, 3, 2, 0
		2.5.Ажилбар хийгддэг өрөөбүрт гар угаах нөхцлийг бүрдүүлсэн байх	1. Ажилбар хийгддэг өрөө бүрт гар угаах угаалтууртай 2. Угаалтуур нь гар угаасны дараа тохой, хөлөөр хаах боломжтой 3. Угаалтуур, тосгуурын хоорондын харьцаа тохирсон 4. Угаалтуур бүр шингэн савантай 5. Нэг удаагийн цаасан алчуур хэрэглэдэг 6. Угаалтуур эвдрэл гэмтэлгүй ажилладаг	5, 4, 3, 2, 0
	2.6.Тусламж, үйлчилгээ үзүүлэх цэг бүрт гар халдваргүйжүүлэх бодистой байх	1. Тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа цэгүүдэд шахуурга бүхий гар халдваргүйжүүлэх бодистой 2. Гар халдваргүйжүүлэх бодисын спиртын агууламж 70-80 хувьтай 3. Бодис нь улсын бүртгэлд бүртгэгдсэн	5, 4, 3, 2, 0	
3.	Эрүүл мэндийн	3.1. Эрүүл мэндийн	1. Эрүүл мэндийн ажилтанг жилд 1 удаа үзлэг, шинжилгээнд	5, 4, 3, 2, 0

ажилтны эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хийдэг байна.	ажилтныг жилд 1-ээс доошгүй удаа халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулдаг байх	хамруулсан /Сүрьеэ, гепатитийн В, С, D вирус, ХДХВ, Метициллинд тэсвэртэй Staphylococcus aureus илрүүлэх үзлэг, шинжилгээ багтсан байх/ 2. Гепатитийн В, С вирусын архаг халдвартай ажилтанг эмчилгээнд хамруулсан 3. Гепатитийн В, С вирусын архаг халдвартай ажилтанг вирусын идэвхижил тодорхойлох шинжилгээнд жил бүр хамруулсан	
	3.2. Шинэ ажилтанг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан байх	1. Үзлэг, шинжилгээнд хамруулахад “Ажилтны эрүүл мэндийн хуудас”-ыг хөтөлж, хуудсыг хувийн хэрэгт хавсаргасан 2. В, С, D вируст гепатит, ХДХВ, тэмбүү, сүрьеэгийн халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан 3. В гепатит, улаанбурхан, гахай хавдар, улаануудын дархлаажуулалтанд хамрагдсан эсэх мэдээллийг авсан 4. В гепатит, улаанбурхан, гахай хавдар, улаануудын вакцинд хамрагдаагүй бол дархлаажуулах, хамрагдсан бол дархлаа тогтоцыг үзүүлсэн 5. Салхинцэцэгээр өвдсөн эсэх мэдээллийг авсан	5, 4, 3, 2, 0
	3.3. Эрүүл мэндийн ажилтны дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл, судалгаатай, дархлаажуулалтад хамруулдаг байх	1. Эрүүл мэндийн ажилтанд хийгдсэн дархлаажуулалтын талаар нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай 2. Архаг халдваргүй, эсрэг заалтгүй бол эмнэлгийн ажилтанг В вируст гепатитийн 3 тун вакцинаар дархлаажуулсан 3. В вируст гепатитийн дархлаажуулалтад хамрагдсан ажилтныг дархлаа тогтоцын шинжилгээнд хамруулсан 4. Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын дархлаажуулалтанд хамрагдсан бүртгэлтэй, өвдсөн эсэхийг асуумжаар тодруулсан 5. Ажилтанг улирлын томуугийн вакцинд хамруулсан	5, 4, 3, 2, 0
	3.4. Эрүүл мэндийн ажилтныг дүрэмт болон хамгаалах хувцас, хэрэгслээр хангасан байх	1. Ажилтан бүр 2-оос багагүй ээлжийн ажлын хувцас (халад, өмд, цамц)-тай 2. Ажлын хувцас биеийн хэмжээнд тохирсон, даавуун материалаар хийгдсэн 3. Эмнэлэгт өмсөх урдуураа битүү гутал, углаашаар хангасан	5, 4, 3, 2, 0
	3.5. Эрүүл мэндийн ажилтны ажлын хувцас хэрэгслийг угаах нөхцлийг бүрдүүлсэн байх	1. Угаалгын хэсгийг зохион байгуулсан 2. Угаагч машин, индүү, хатаагчтай 3. Эрүүл мэндийн ажилтны ажлын хувцас хэрэгслийг эмнэлгийн бусад хэрэгсэлтэй хамт угаадаггүй	5, 4, 3, 2, 0

			4. Угаагч бодис, шаардлагатай үед ашиглах халдваргүйжүүлэх бодисоор хангасан 5. Угаалгын хэсэгт ажиллах ажилтан хамгаалах хувцас хэрэгсэл хэрэглэдэг	
4.	Ариутгалын хэсгийг ажиллуулж цэвэр, ариун, аюулгүй байдлыг хангасан багаж, хэрэгслээр тусламж, үйлчилгээ үзүүлнэ.	4.1. Төв нь давтан хэрэглэж байгаа багаж хэрэгсэл, хөвөн шарик ариутгах ариутгалын хэсэгтэй эсвэл гэрээгээр гүйцэтгүүлдэг байх	1. Ариутгалын хэсэг нь бохир, цэвэр хэсгээр тусгаарласан, гэрээгээр гүйцэтгүүлдэг бол албан ёсны гэрээтэй 2. Өрөөний урсгалыг зөв зохион байгуулсан, эрүүл ахуйн шаардлага хангасан (гэрээгээр бол хамаарахгүй) 3. Анхан шатны маягтыг бүрэн хөтөлдөг, гэрээгээр гүйцэтгүүлдэг бол ариун материал хүлээж авсан, хүлээлгэн өгсөн бүртгэлтэй 4. Давтан ашиглах багаж хэрэгсэл, материалын жагсаалтыг гаргасан 5. Ариутгалын ажилтан нь мэргэжил олгох сургалтанд хамрагдсан, гэрчилгээтэй (гэрээгээр бол хамаарахгүй)	5, 4, 3, 2, 0
		4.2. Ариутгалын хэсэг нь багаж, хэрэгслийг ариутгах шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	1. Тоног төхөөрөмжийн ажиллагаа нь хэвийн 2. Бохир багаж хэрэгслийг гараар угаах хэрэгсэл болон зориулалтын угаах автомат машинтай 3. Хатаах шүүгээ эсвэл өрөөний хэмд хатаах тавиур, ширээ, арчиж хатаах даавуун алчуураар хангагдсан 4. Автомат тохируулга бүхий бага оврын автоклавтай, нөөц ариутгагчтай 5. Ус нэрэгч болон ус шүүх төхөөрөмжтэй 6. Зориулалтын боолтын материалаар боож, савладаг 7. Томруулах шил, угаах сойз гэх мэт бусад дагалдах хэрэгслээр хангагдсан 8. Төв нь тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгүүлэх гэрээтэй ажилладаг /хэрэв гэрээтэй бол дээрх үзүүлэлтүүд хамаарахгүй/	5, 4, 3, 2, 0
		4.3. Багажийн цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтэд улсын бүртгэлд бүртгэгдсэн бодисыг ашигладаг байх	1. Багажны угаалганд биологийн бохирдол арилгах бодис ашигладаг 2. Бүртгэлийн гэрчилгээтэй цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх бодис ашигладаг 3. Бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж, хэрэглэсэн	5, 4, 3, 2, 0
		4.4. Ариутгалын үйл ажиллагаанд хяналт тавьдаг	1. Багажны цэвэрлэгээний үр дүнг уураг болон цусны үлдэгдэл тодорхойлох тестээр сард 1-ээс доошгүй удаа	5, 4, 3, 2, 0

		байх	<p>хянадаг</p> <ol style="list-style-type: none"> 2. Боолт, савалгаатай багаж бүрт гадна индикатороор хяналт тавьдаг 3. Боолт, савалгаатай багаж бүрийн дотор талд индикатороор хяналт тавьдаг 4. Автоклавын камер доторх уурын тархалтыг сард 1-ээс доошгүй удаа хянадаг 5. Автоклавын үйл ажиллагаанд биологийн тестийн хяналтыг сард 1-ээс доошгүй удаа хийдэг 	
		4.5.Багаж хэрэгслийн арчилгаа, савалгаа, хадгалалт зөв байх	<ol style="list-style-type: none"> 1. Давтан хэрэглэж байгаа багаж эвдрэл гэмтэлгүй, зэврээгүй 2. Хэрэглэх байдлаар багцалж савладаг 3. Зориулалтын боолт, савалгааны материал ашигладаг 4. Хадгалах, хэрэглэх явцад бохирдлоос сэргийлэгдсэн, ариун материал хадгалах битүү шүүгээтэй 5. Хадгалалтын хугацааг мөрддөг 	5, 4, 3, 2, 0
5.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар /ЭТҮХХ/ илрүүлэх тандалтыг хийж, дүгнэлт өгч, хариу арга хэмжээ авдаг байна.	5.1. Мэс заслын дараах шархны халдвар илрүүлж, бүртгэж, мэдээлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Мэс заслын хийгдсэн үйлчлүүлэгч шархны халдварын улмаас эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн тохиолдлыг бүртгэсэн 2. Дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад халдварын тохиолдлыг мэдээлсэн 	5, 4, 3, 2, 0
		5.2. Төрсний дараа эх, нярайн халдвар илрүүлэх тандалт хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Төрсний дараа эх, нярай төвөөр үйлчлүүлэх болон гэрийн эргэлт хийх үед халдвар илрүүлэх тандалт хийсэн 2. Тандалтаар илрүүлсэн ЭТҮХХ-ын тохиолдлыг бүртгэсэн 3. Халдвар илэрсэн тохиолдолд дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад мэдээлсэн 	5, 4, 3, 2, 0
		5.3.Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх арга хэмжээ авдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Антибиотикийн зохистой хэрэглээний байдалд хяналт тавьдаг 2. Заалтгүйгээр антибиотик хэрэглэдэггүй 3. Антибиотикийн хэрэглээний байдалд дүн шинжилгээ хийдэг 4. Иргэдэд бактерийн эсрэг эмийн талаар зөв мэдээлэл өгөх ухуулга, нөлөөллийн ажил хийдэг 	5, 4, 3, 2, 0
6.	Шинэ вирусийн халдвар, халдварт өвчний дэгдэлтэд бэлэн байдлыг хангаж ажиллана.	6.1. Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангаж ажилладаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах төлөвлөгөөтэй 2. Бэлэн байдалд дасгал сургуулилт хийдэг 3. Ахмад настай, нярай хүүхэд, архаг суурь өвчтэй гэх мэт үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн судалгаатай 	5, 4, 3, 2, 0

			4. Дайчлагдан ажиллах боломжтой хүний нөөцийн бүртгэл судалгаа, төлөвлөлттэй	
		6.2. Халдварт өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зохион байгуулалт хийдэг байх	1. Халдварын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгчийн үзлэгийн өрөөг тусад нь зохион байгуулах боломжтой 2. Хүлээлгийн хэсгийг бөөгнөрөл, дараалал үүсгэхээргүй зохион байгуулсан 3. Хөтөч ажилтан болон дуугүй хөтөч ажиллуулдаг, үүдээр орох хэсэгт ангилан ялгалт хийдэг 4. Гэрийн эргэлт, гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлдэг 5. Үйлчлүүлэгчдэд зориулан халдвараас сэргийлэх санамж, анхааруулга өгдөг	5, 4, 3, 2, 0
		6.3. Хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисын нөөцтэй байх	1. Шүүлтүүртэй амны хаалт, амны хаалт, комбинзон, халад, нүдний шил, нүүрний хамгаалалт, хормогч, ханцуйвч, усны гутал, гутлын гадуурх улавч, бээлий зэрэг нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн 2. Хамгаалах хувцас хэрэгслийн үзүүлэлт, чанар нь халдвартай орчинд хэрэглэх шаардлага хангасан 3. Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчид зүүлгэх амны хаалт, үзлэгийн хэсэгт бэлэн байдаг 4. Гар халдваргүйжүүлэх болон орчны гадаргуу халдваргүйжүүлэх бодис хамгийн багадаа 1 сар хэрэглэх нөөцтэй	5, 4, 3, 2, 0
7.	Үйлчлүүлэгчид ээлтэй тав тухтай орчинг бүрдүүлсэн байна.	7.1. Эмнэлгийн зориулалтын, эрүүл ахуйн шаардлага хангасан байртай байх	1. Өрөөнүүдийн талбайн хэмжээ стандартын шаардлага хангасан 2. Өрөөнүүд дулаан, гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, тохитой 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин(ханын бариул, тусгай өрөө, тэргэнцэртэй орох боломж, бариул, түшлэгтэй ариун цэврийн өрөө гэх мэт) бүрдүүлсэн	5, 4, 3, 2, 0
		7.2. Үйлчлүүлэгчид зориулсан ариун цэврийн өрөөний хангалт, тохижилт стандартын шаардлага хангасан байх	1. Ариун цэврийн өрөө, жорлонгийн суултуур, угаалтуур эвдрэл гэмтэлгүй, цэвэр, тохь тухтай орчинг бүрдүүлсэн 2. Хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг бол хүүхдийн ариун цэврийн өрөөтэй, хүүхдийн угаалтуур, суултуурыг тохижуулсан	5, 4, 3, 2, 0
		7.3. Байгууллагын орчин	1. Өрөө тасалгааг бүсээр ангилан цэвэрлэгээ хийх хуваарь,	5, 4, 3, 2, 0

		цэвэрхэн, цэвэрлэгээг зааврын дагуу хийдэг байх	заавартай 2. Өдөр бүр чийгтэй цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийдэг 3. Хүний гар хүрдэг талбайг өдөрт 3-аас доошгүй удаа цэвэрлэж, халдваргүйжүүлдэг 4. Цэвэрлэгээний чанарыг шалгах хуудсаар үнэлдэг 5. Цэвэрлэгээний материалыг угааж, халдваргүйжүүлэх хадгалах боломж, нөхцлийг бүрдүүлсэн	
		7.4. Өрөө, тасалгаанд шавж, мэрэгч үүрлээгүй, урьдчилан сэргийлэх устгалыг хийлгэдэг байх	1. Өрөө, тасалгаа, дээвэр, хонгилд шавж, мэрэгч үүрлэхээс сэргийлж шавж, мэрэгч устгалыг жил бүр хийлгэсэн 2. Үүрлэсэн тохиолдолд тухай бүр устгал хийлгэдэг	5, 4, 3, 2, 0
8.	Хог хаягдлын менежементийг зохион байгуулсан байна.	8.1.Хог хаягдлыг зохих журмын дагуу зөв ангилан ялгаж цуглуулдаг байх	1. Хог хаягдал үүсч байгаа цэг бүрт ангилан цуглуулах нөхцөл бүрдсэн 2. Хог хаягдлыг зөв ангилж ялгасан	5, 4, 3, 2, 0
		8.2.Эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлыг цуглуулах, зөөх уут сав нь чанарын шаардлага хангасан байх	1. Аюулгүй хайрцаг нь (цаасан, хуванцар) шингэн нэвчээгүй, зүү нэвтэрдэггүй 2. Биоаюулгүйн таних тэмдэг бүхий зориулалтын уутанд халдвартай хог хаягдлыг цуглуулдаг 3. Хогийн сав нь гар оролцохгүй нээж, хаагддаг 4. Хог хаягдлын уут, сав нь гарч байгаа хог хаягдлын хэмжээнд тохирохоор багтаамжтай 5. Хог хаягдлыг зөөх явцад асгарахаас сэргийлж тагтай, бариултай саваар зөөдөг	5, 4, 3, 2, 0
		8.3.Хог хаягдлыг түр хадгалах цэг, байртай байх	1. Шаардлага хангахуйц түр хадгалах цэгтэй 2. Хогийг хэмжих жин, гар угаах угаалтууртай 3. Аюултай хог хаягдал тус бүрээр кг-аар тооцож бүртгэсэн 4. Хог хаягдлын ажилтан хамгаалах хувцас хэрэгслээр хангагдсан	5, 4, 3, 2, 0
		8.4.Аюултай хог хаягдлын устгалыг зөвшөөрөл бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байх	1. Аюултай хог хаягдлыг устгах эрх бүхий байгууллагатай гэрээтэй эсвэл байгаль орчинд халгүй аргаар устгадаг 2. Эмнэлгээс гарч байгаа аюултай хог хаягдлыг нэгтгэн сар бүр мэдээлдэг	5, 4, 3, 2,0
Онооны дүн		Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэд бүлэг 1. ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
	Байгууллагын бүтэц, орон тоог баталж, тусламж, үйлчилгээний чиглэлийн дагуу зохион байгуулсан байна.	1.1.Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх бүтэц, зохион байгуулалтыг хийсэн байх	1. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт (MNS)-тай уялдуулан бүтэц, зохион байгуулалтыг баталсан тушаалтай 2. Нэгж, хэсгүүдийг бүрэн зохион байгуулсан	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.2. Батлагдсан тусламж, үйлчилгээний жагсаалтын дагуу үйл ажиллагаа явуулдаг байх	1. Үзүүлж тусламж, үйлчилгээ бүрээр жагсаалттай 2. Тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлдэг 3. Хяналт тавьдаг	5, 4, 3 2, 0
		1.3.Өдрийн эмчилгээг зохион байгуулсан байх	1. Өдрийн эмчилгээний баталсан журамтай, мөрддөг 2. Өдрийн эмчилгээ, ажилбар хийх стандарт, удирдамжийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг 3. Эмчилгээг эмчийн заалтаар хийдэг	5, 4, 3 2, 0
2.	Байгууллагын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангаж ажиллана.	2.1.Бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах зохицуулалтыг хийсэн байх	1. Бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, үйл ажиллагааны журамтай, баталгаажуулсан 2. Хамтран ажилласан чиглэл, гарсан үр дүнг тооцсон	5, 4, 3 2, 0
		2.2 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж мэргэжил аргагүйн дэмжлэг авдаг байх	1. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах журамтай, журмыг хэрэгжүүлдэг 2. Мэргэжил арга зүйн зөвлөгөө авсан тайлан, дүгнэлттэй	5, 4, 3 2, 0
3.	Байгууллагыг хөгжүүлэх төлөвлөлтийг хийж, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.	3.1. Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй, хэрэгжилтэд явцын болон төгсгөлийн үнэлгээ хийсэн, үр дүнг тооцсон байх	1. Байгууллагын стратеги төлөвлөгөөг салбарын бодлого, харъяалах орон нутгийн бодлоготой уялдуулан баталж, хэрэгжүүлсэн 2. Төлөвлөгөөнд хийсэн явцын, төгсгөлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, цаашид анхаарах санал, зөвлөмжийн хэрэгжилтийг тусгасан 3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хийгдсэн явцын болон төгсгөлийн үнэлгээний дүгнэлтийг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэлтэй, гарсан шийдвэр, түүнийг хэрэгжүүлсэн	5, 4, 3 2, 0

			<p>4. Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд хамт олны оролцоог хангасан</p> <p>5. Төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр дүгнэдэг, тайлантай</p>	
		3.2. Жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан, хэрэгжилтийг тоодог байх	<p>1. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулж, батлан хэрэгжүүлсэн</p> <p>2. Жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, тайлан, дүгнэлт</p>	5, 4, 3 2, 0
4.	Байгууллагын засаглалын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн байна.	4.1. Нөхөрлөлийн багийн үйл ажиллагаа хэвшиж, үр дүнтэй ажилладаг байх	<p>1. Нөхөрлөлийн бүрэлдэхүүнийг баталсан тушаалтай</p> <p>2. Батлагдсан журмын дагуу ажилладаг /хурлын тоо, хурлын тэмдэглэл, гарсан шийдвэр, түүний биелэлт-эргэх холбоо/</p> <p>3. Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт ажилтны 70-аас доошгүй хувийг нөхөрлөлд оруулсан</p> <p>4. Нөхөрлөлийн хурлаар төвийн үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэлэлцэж шийдвэрлэдэг</p>	5, 4, 3 2, 0
5.	Байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй дотоодын хяналтыг хийдэг тогтолцоотой байна.	5.1. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийгдэх хяналт, үнэлгээ хэвшсэн байх	<p>1. Дотоод хяналт, үнэлгээний багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан тушаалтай</p> <p>2. Дотоод хяналт, үнэлгээний батлагдсан төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэл бүрээр хяналт, үнэлгээ хийх хуваарьтай</p> <p>3. Хяналтын хуудсыг чиглэл бүрээр боловсруулж, баяжуулдаг, хэрэглэдэг</p> <p>4. Хийгдсэн хяналт, үнэлгээний тайлан, дүгнэлттэй</p> <p>5. Гарсан зөвлөмж, түүний дагуу ажил хийгдсэн</p> <p>6. Хяналт, үнэлгээний дүгнэлтийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн, асуудлыг шийдвэрлүүлсэн</p>	5, 4, 3 2, 0
6.	Хариуцлагатай, үр дүнтэй манлайллын тогтолцоо бүрдсэн байна.	6.1. Бүх ажилтнуудын хурлыг тогтмол хийж, байгууллагын бодлого, шийдвэрийг танилцуулдаг, тэдний санал бодлыг сонсдог үйл ажиллагаа тогтмолжсон байх	<p>1. Байгууллагын ажилтнуудын хурлын тэмдэглэлтэй</p> <p>2. Гарсан шийдвэр, түүний дагуу авсан арга хэмжээний үр дүнг дүгнэсэн</p> <p>3. Эргэн мэдээлэл хийгдсэн</p>	5, 4, 3 2, 0
		6.2. Тусламж, үйлчилгээний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, зохион байгуулалтын арга	<p>1. Тусламж, үйлчилгээний нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээний тайлантай</p> <p>2. Авч хэрэгжүүлсэн зохион байгуулалтын арга хэмжээний</p>	5, 4, 3 2, 0

	хэмжээ авдаг тогтолцоотой байх	төрөл, удаа	
	6.3. Ажилтнуудад хууль зүйн ба сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх	1. Хууль эрх зүйн зөвлөгөө авсан ажилтны тоо/бүртгэл 2. Сэтгэл зүйн зөвлөгөө авсан ажилтны тоо/бүртгэл 3. Ажилтнуудын сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүн 4. Нөхцөл бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (хууль, эрх зүйн цахим мэдээний сан, тохижуулсан өрөө, гарын авлага, ном товхимол гэх мэт)	5, 4, 3 2, 0
	6.4.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр/төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнтэй ажилладаг байх	1. Байгууллагын хэмжээнд ажлын байрны орчны үнэлгээ хийлгэсэн 2. Ажлын байрны орчинг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн 3. Тусламж, үйлчилгээтэй холбоотой ажлын байрны орчинд үүсч болох эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авсан 4. Хувийн хамгаалах хэрэгслээр хангасан, хүртээмжтэй 5. Эрсдэл, ослын бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
Онооны дүн	Авбал зохих оноо	...	
	Авсан оноо	...	

Дэд бүлэг 2.ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН УДИРДЛАГА

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.	1.1 Байгууллага нь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” /Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө/-тэй, хэрэгжүүлж, хянадаг байх	1. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг баталсан 2. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэдэг, үр дүнг жил бүр тооцсон, тайлантай 3. Төлөвлөгөөнд магадлан итгэмжлэлийн шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийг бүрэн тусгаж, хэрэгжүүлсэн	5, 4, 3 2, 0
		1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал /ЭМТҮЧАБ/-ын багийн үйл ажиллагаа тогтмолжсон, асуудалд чиглэсэн тодорхой, үр дүнтэй ажилладаг байх	1. Холбогдох тушаал, шийдвэрт заасны дагуу чанар, аюулгүй байдлыг сайжруулах багийг зохион байгуулж, гишүүдийг томилсон 2. ЭМТҮЧАБ-ын багийн гишүүдийн албан тушаалын тодорхойлолт /АТТ/-д холбогдох тушаал, шийдвэрт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгаж баталсан 3. АТТ-д заасан чиг үүргийн дагуу ажиллуулдаг 4. Төвийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд	5, 4, 3, 2, 0

			жил бүр дүн шинжилгээ хийсэн, гарсан ахиц, үр дүнтэй	
		1.3. Чанар, аюулгүй байдал /ЧАБ/-ыг сайжруулах үйл ажиллагаанд эмнэлгийн мэргэжилтнүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Төвийн удирдлага, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтнуудын АТТ-д чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийх ажлыг тусгасан 2. Бүх ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд ЧАБ-ын чиглэлээр хийсэн ажлыг үнэлдэг шалгууртай 3. ЧАБ-ын чиглэлээр үр дүнтэй ажилласан ажилтнуудад урамшуулал олгох эрх зүйн зохицуулалтыг хийж, хэрэгжүүлдэг 	5, 4, 3, 2, 0
2.	Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж, хянаж сайжруулдаг байна.	2.1. Төв нь тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд дотоод хяналт, үнэлгээг тогтмол хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын дотоод хяналт, үнэлгээ хийх төлөвлөгөө, хуваарьтай ажилладаг 2. Хяналт, үнэлгээнд хяналтын хуудсууд ашигладаг 3. Хяналт, үнэлгээний тайлан, дүгнэлттэй 4. Дотоод хяналтаар илэрсэн асуудлыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, сайжруулах арга хэмжээ авч ажилладаг, үр дүн гарсан 	5, 4, 3, 2, 0
		2.2. Үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээнд тохирсон чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Тусламж, үйлчилгээний төрөл бүрээр /өвчлөл, нас баралт, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэлттэй уялдуулан/ баталсан чанарын шалгуур үзүүлэлттэй, үзүүлэлт тус бүрийн суурь түвшинг тодорхойлсон 2. Шалгуур үзүүлэлтийг тогтмол хэмжиж, дүн шинжилгээ хийсэн дүгнэлт, тайлантай 3. Дүгнэлтийг үйл ажиллагаандаа ашигладаг 4. Тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт сайжирсан, ахиц өөрчлөлт гарсан 5. Улс, аймаг, Улаанбаатар хотын дундаж үзүүлэлттэй харьцуулан үнэлдэг /Улс, аймаг, УБ хотын дундажтай харьцуулсан хувь/ 	5, 4, 3, 2, 0
		2.3. Чанарыг тасралтгүй сайжруулах арга хэмжээ зохион байгуулдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Тусламж, үйлчилгээнд жил бүр шинэ технологи, сайн туршлагыг нэвтрүүлж, үр дүнг тооцсон 2. Байгууллагын хэмжээнд чанар сайжруулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, ажилтнуудын оролцоог хангасан 3. Жил бүр 2-оос доошгүй удаа чанар, аюулгүй байдлын сургалт зохион байгуулж, ажилтнуудыг бүрэн хамруулсан 4. Чанар сайжруулах аргуудыг хэрэглэдэг, “Чанарын өдөрлөг”-ийг тогтмол зохион байгуулдаг 	5, 4, 3, 2, 0

		2.4. Оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, эмнэлзүйн зааврыг мөрдөж ажилладаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын үзүүлж буй тусламж, үйлчилгээнд мөрдөх стандарт, удирдамж, заавар болон эрх зүйн баримт бичгийн нэгдсэн жагсаалтыг баталсан, баяжилт хийдэг 2. Ажилтан бүр стандарт, удирдамж, эмнэлзүйн зааврыг ашиглах боломжоор хангагдсан /Цахим, CD, гарын авлага гэх мэт/ 3. Стандарт, удирдамж, эмнэлзүйн зааврыг хэрэгжүүлэх талаар сургалтыг тогтмол зохион байгуулдаг 4. Олон улсын хэмжээнд мөрдөж байгаа удирдамж, эмнэлзүйн заавар, гарын авлагыг ашиглах боломж нөхцөлийг бүрдүүлсэн 	5, 4, 3, 2, 0
3.	Байгууллагын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад үйлчлүүлэгчийн оролцоог хангасан байна.	3.1. Үйлчлүүлэгчээс авсан сэтгэл ханамжийн судалгааг тухай бүр дүгнэдэг, гарсан асуудалд чиглэсэн тодорхой арга хэмжээ авдаг, дүн шинжилгээ харьцуулалт хийж хэвшсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Сэтгэл ханамжийн судалгааны асуумж, арга аргачлалыг баталж, судалгааг тогтмол зохион байгуулдаг 2. Судалгаанд дүн шинжилгээ хийн асуудлыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 3. Тодорхойлсон асуудалд чиглэсэн авсан арга хэмжээ, үр дүнг танилцуулсан 	5, 4, 3, 2, 0
		3.2. Ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааг тухай бүр дүгнэдэг, гарсан асуудалд чиглэсэн тодорхой арга хэмжээ авдаг, дүн шинжилгээ харьцуулалт хийж хэвшсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийн асуудлыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 2. Тодорхойлсон асуудалд чиглэсэн авсан арга хэмжээ, үр дүнг танилцуулсан 	5, 4, 3, 2, 0
		3.3. Ёс зүйн алдаа зөрчлийг мэдээлэх, бүртгэх тогтолцоотой байх	<ol style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрддөг 2. Ёс зүйн алдаа зөрчлийг мэдээлэх, бүртгэх журам, бүртгэлийн сантай 3. Удирдах ажилтны ёс зүйн хэмж хэмжээг баримталдаг 4. Эмнэлгийн ажилтнуудын харилцаа, хандлага, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг төлөвлөн зохион байгуулдаг, хэвшсэн 5. Иргэдийн гомдол саналыг бүртгэн, шийдвэрлэсэн 	5, 4, 3, 2, 0
4.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион	4.1. Тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах журамтай, зохион байгуулалтыг бүх нэгжид хийсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн батлагдсан журамтай, хэрэгжүүлсэн, үр дүнг дүгнэдэг 2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажил, үр дүн 3. Үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 	5, 4, 3, 2, 0

	байгуулдаг байна.		хийсэн ажил, үр дүн	
		4.2 Тусламж, үйлчилгээг үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Төв нь холбогдох журам, зааврыг үндэслэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан баталсан тохиолдол бүртгэх, хариу арга хэмжээ авах баталсан журамтай, мөрддөг 2. Тохиолдол мэдээлэх ажилтанг томилсон тушаалтай 3. Тохиолдлын санд нэвтрэх нэр, код авсан 4. Тохиолдлын санд мэдээлсэн удаа 5. Бүртгэгдсэн тохиолдол бүрт дүн шинжилгээ хийн, хэлэлцүүлдэг 6. Тохиолдлын мөрөөр арга хэмжээ авч, хэрэгжүүлдэг 	5, 4, 3, 2, 0
		4.3. Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон ажилтан, үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Аюулгүй байдалтай холбоотой алдаанаас хохирсон ажилтан, үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлэх батлагдсан журамтай, хэрэгжүүлдэг 2. Дэмжлэг үзүүлсэн төрөл, тоо, баримттай 	5, 4, 3, 2, 0
4.4. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой сургалтыг эмнэлгийн нийт ажилтнуудад /эмнэлгийн болон эмнэлгийн бус мэргэжилтнүүдэд/ тогтмол зохион байгуулдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Сургалтын удирдамж, хөтөлбөртэй 2. Сургалтын тайлантай 3. Оролцогчдын бүртгэлтэй 	5, 4, 3, 2, 0		
5.	Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.	5.1. Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тогтмолжуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба/ баг нь холбогдох журам, зааврын дагуу байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилладаг 2. Байгууллагын түвшинд эрсдэлийг бүртгэх тогтолцоо бүрдсэн (Эрсдэл бүртгэдэг арга /цахим болон цаасан/) 3. Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлсэн үйл ажиллагаа хийдэг 4. Үнэлгээнд үндэслэн боловсруулсан эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөтэй, хэрэгжилт, үр дүнг тооцсон 5. Эрсдэлийн мэдээний сантай, бүртгэдэг 6. Өндөр эрсдэл болон ноцтой үр дагавар бүхий эрсдэлийг холбогдох байгууллагад мэдээлсэн 	5, 4, 3, 2, 0
		5.2. Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр байгууллагын	<ol style="list-style-type: none"> 1. Нийт ажилтнуудыг эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээг авах чиглэлээр сургадаг 2. Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээг авах 	5, 4, 3, 2, 0

		ажилтнуудыг сургадаг байх	төлөвлөгөө боловсруулахад ажилтнуудын оролцоог хангасан 3. Сургалтын удирдамж, хөтөлбөртэй	
		5.3. Барилга байгууламжийн засвар, үйлчилгээний өмнө болон явцад гарч болох эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авдаг байх	1. Барилга байгууламжийн засвар, үйлчилгээний өмнө эрсдэлийг тооцож арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн 2. Засварын явцад аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажилладаг	5, 4, 3, 2, 0
6.	Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтын мөрөөр арга хэмжээ авч, хэрэгжүүлдэг байна.	6.1 Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажилладаг байх	1. Санхүүгийн байгууллага, аудитын хяналт, шалгалтын дүгнэлт, гарсан зөрчлийг арилгах талаар авсан арга хэмжээ, үр дүн 2. Мэргэжлийн хяналтын болон эрүүл мэндийн даатгалын байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт, авсан арга хэмжээ, үр дүн гарсан 3. Тайлан, дүгнэлттэй	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

Дэд бүлэг 3.ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
	Байгууллагын хөгжлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүний нөөцөөр хангасан байна.	1.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний хэрэгцээнд үндэслэн хүний нөөцийн төлөвлөлтөө хийж, хангасан байх	1. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны /MNS/ стандартад заасан хүний нөөцийн хангалтын хувь 2. Байгууллагын даргын тушаалаар батлагдсан орон тооны хангалтын хувь 3. Хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ 4. Авсан арга хэмжээний үр дүн, тайлантай	5, 4, 3, 2, 0
		1.2. Хүний нөөцийн хөгжлийн (төгсөлтийн дараах сургалт, эрдмийн болон мэргэжлийн зэрэг, нийгмийн хамгаалал гэх мэт) хөтөлбөр/төлөвлөгөө батлан, хэрэгжүүлдэг байх	1. Хүний нөөцийн хөгжлийн батлагдсан төлөвлөгөөтэй ажилладаг 2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцдог, тайлантай	5, 4, 3, 2, 0
		1.2. Хүний нөөцийн хангалт,	1. Хүний нөөцийн хөгжилд жил бүр хийсэн судалгаа/дүн	5, 4, 3, 2, 0

		хөгжилд жил бүр судалгаа/дүн шинжилгээ хийж хэвшсэн байх	шинжилгээний тайлантай 2. Дүгнэлт, үр дүнг үндэслэн авсан арга хэмжээ	
		1.3. Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийлгэж, арга хэмжээ авдаг байх	1. Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд холбогдох мэргэжлийн байгуулагаар үнэлгээ хийлгэсэн 1. Үнэлгээний мөрөөр арга хэмжээ авч, дүгнэсэн 2. Хөдөлмөрийн норм нормативыг үндэслэн ажлын ачааллыг тэнцвэржүүлэхээр авсан арга хэмжээ	5, 4, 3, 2, 0
		1.5. Ажилтан бүрийн албан тушаалын тодорхойлолтыг тусламж, үйлчилгээний өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, баталгаажуулсан байх	1. Ажилтан бүр батлагдсан албан тушаалын тодорхойлолт /АТТ/-той 2. АТТ-ыг тусламж, үйлчилгээний өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, баталгаажуулсан 3. АТТ-д ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийг бүрдүүлэх, сайжруулах талаар тусгасан	5, 4, 3, 2, 0
		1.6. Ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан, гэрээний биелэлтийг дүгнэдэг байх	1. Ажилтан бүртэй байгуулж баталгаажуулсан хөдөлмөрийн гэрээтэй 2. Гэрээний биелэлтийг дүгнэдэг, урамшуулал, хариуцлагын тогтолцооны уялдааг хангасан	5, 4, 3, 2, 0
		1.7. Ажилтан нэг бүрээр хувийн хэргийг бүрдүүлсэн, баяжилт хийгддэг байх	1. Ажилтан бүрийн хувийн хэргийг тавигдах стандарт, шаардлагын дагуу бүрдүүлсэн 2. Жил бүр баяжилт хийгдсэн	5, 4, 3, 2, 0
2.	Хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоотой байна.	2.1. Ажилтныг сонгон шалгаруулалтаар ажилд авдаг журамтай, хэрэгжүүлдэг байх	1. Ажилтанг сонгон шалгаруулалтаар ажилд авах батлагдсан журам, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлттэй 2. Сонгон шалгаруулалтын журмын дагуу хийсэн	5, 4, 3, 2, 0
		2.2. Шинэ ажилтанг чиглүүлэх, дадлагажуулах сургалтад хамруулдаг тогтолцоо бүрдсэн байх	1. Шинэ ажилтанг чиглүүлэх, дадлагажуулах сургалтын батлагдсан хөтөлбөртэй, мөрддөг 2. Үр дүнг тооцсон, тайлантай	5, 4, 3, 2, 0
3.	Хүний нөөцийг хөгжүүлэх арга хэмжээ авч, шийдвэрлэдэг	3.1. Хүний нөөцийг ажлын байран дээр тасралтгүй суралцах нөхцөл, боломжоор хангасан байх	1. Ажлын байран дээр суралцах нөхцөлөөр хангасан байдал /өрөө, тасалгаа, номын сан, цахим сан, сургалтын хэрэглэгдэхүүн/ 2. Ажлын байрны сургалтыг тогтмол зохион байгуулдаг	5, 4, 3, 2, 0

	байна.	3.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад, дотоод сургалтанд хамруулж хөгжүүлдэг тогтолцоо бүрдэж, үйл ажиллагаа хэвшсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлэх хүрээний хүн амын өвчлөл, оношилгоо, эмчилгээний технологийн дэвшил зэрэгт нийцүүлэн жил бүр сургалтын хэрэгцээг тодорхойлон, түүнд үндэслэн дотоодын сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн 2. Сургалтын хэрэгцээг тогтоосон судалгааны тайлан, дүгнэлт 3. Эмч, эмнэлгийн мэргэжилтний багц цагийн сургалтанд хамрагдсан мэдээний сантай 4. Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад, дотоод сургалтын талаар байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн 5. Сургалтын тайлантай 	5, 4, 3, 2, 0
		3.3.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн мэргэжилтэн бүр ёс зүйн хэм хэмжээг мөрддөг 2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан 3. Эмнэлгийн мэргэжилтний харьцаа хандлага, ёс зүйн чиглэлээр сургалт хийдэг 4. Ажилнуудын ажлын үнэлгээнд харьцаа хандлага, ёс зүйн шалгуур үзүүлэлтийг оруулж, дүгнэдэг 	5, 4, 3, 2, 0
		3.4 Үзүүлж байгаа, тусламж, үйлчилгээндээ дүн шинжилгээ хийж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийдэг, хэвшсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо, төрөл 2. Хэлэлцүүлсэн байдал 3. Хэвлэж, нийтэлсэн бүтээл 4. Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан тайлан 	5, 4, 3, 2, 0
		3.5.Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлж, ур чадварыг дээшлүүлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн мэргэжилтнүүд нь мэргэшсэн 2. Жил бүр эрдмийн цол болон мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэхэд идэвхтэй ажиллаж, байгууллагаас дэмжлэг үзүүлсэн 3. Жил бүр шинээр мэргэжлийн зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн дунд мэргэжилтний тоо, мэргэжлийн төрөл, хувь 	5, 4, 3, 2, 0
4.	Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлдэг, урамшууллын	4.1 Ажилтнуудын ажилд гүйцэтгэлийн үнэлгээ хийдэг, хэвшсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Ажилтнуудын ажилд гүйцэтгэлийн үнэлгээ хийх батлагдсан журам, шалгуур үзүүлэлттэй 2. Үнэлгээг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гарсан шийдвэр, бусад баримт бичигтэй 	5, 4, 3, 2, 0

	тогтолцоог бүрдүүлсэн байна.		3. Урамшуулал олгосон ажилтны тоо, хувь	
5.	Ажилтнуудын ажлын орчин нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллана.	5.1 Ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд ажлын нөхцөл, сургалт, хөгжил, нийгмийн асуудлыг тусган шийдвэрлэдэг байх	1. Ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд сургалт, хөгжил, нийгмийн асуудлыг тусгасан асуудлаар сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авсан 2. Судалгааны дүгнэлтэд үндэслэн тодорхой үйл ажиллагааг холбогдох төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн 3. Урамшуулал, нийгмийн асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэдэг 4. Ажлын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлантай	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	
		Авсан оноо	

Дэд бүлэг 4. МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Байгууллагын мэдээллийн тогтолцоог өргөжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажилладаг байна.	1.1.Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд мэдээллийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг тусгасан, хэрэгжүүлдэг байх	1. Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд мэдээллийн удирдлагыг сайжруулах ажлыг төлөвлөсөн, 2. Хийгдсэн арга хэмжээний тайлан, гарсан үр дүн, дүгнэлт	5, 4, 3 2, 0
		1.2.Тусламж, үйлчилгээнд цаг товлох үйлчилгээг нэвтрүүлсэн байх	1. Баталсан цагийн хуваарьтай, ил тод байдлыг хангасан 2. Цаг товлох үйлчилгээний зохицуулалт, үйл ажиллагаа хэвшсэн	5, 4, 3 2, 0
		1.3.Байгууллага нь тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүд, хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, санхүү зэрэг чиглэлээр 5 жилээс доошгүй хугацаагаар үүсгэсэн мэдээний сантай байх	1. Мэдээний сантай, жил бүр хийсэн баяжилт хийдэг 2. Хийгдсэн харьцуулалт, дүн шинжилгээтэй 3. Шийдвэр гаргалт, төлөвлөлт, судалгаа шинжилгээний ажилд ашигласан байдал	5, 4, 3 2, 0
2.	Мэдээ, мэдээллийн ил тод байдлыг	2.1 Эрүүл мэндийн даатгал, төр хариуцан төлж буй тусламж,	1. Эрүүл мэндийн даатгал, төр хариуцан төлж байгаа тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, нэр төрлийн	5, 4, 3 2, 0

	хангасан байна.	үйлчилгээний мэдээллийн ил тод байдлыг хангасан байх	жагсаалтыг баталгаажуулж, ил тод (цахим хуудас, мэдээллийн самбар гэх мэт) байрлуулсан 2. Лавлагаа мэдээллийн ажилтан мэдээлэл өгдөг	
		2.2.Байгууллага нь тусламж, үйлчилгээний зохицуулалтын мэдээллээр хангасан байх	1. Үзүүлж буй тусламж, үйлчилгээний (өдрийн эмчилгээ, үйлчилгээ) зохицуулалтын мэдээллийг ил тод байршуулсан, иргэдэд мэдээлдэг 2. Үйлчлүүлэгчид өгөх мэдээ, мэдээллийн урсгалыг тодорхойлж, ил тод байршуулсан, хэрэгжүүлдэг	5, 4, 3 2, 0
		2.3. Үйлчлүүлэгч зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөл, боломж бүрдүүлсэн байх	1. Эмнэлэгт хэвтүүлэхээр илгээсэн үйлчлүүлэгчид хэвтэхийн өмнө болон эмнэлгээс гарсны дараа зөвлөгөө мэдээлэл авахад туслах утсан холбоо, цахим шуудангийн үйлчилгээг нэвтрүүлсэн 2. Мэдээлэл, зөвлөгөө өгдөг утас, хариуцсан ажилтантай 3. Үйлчилгээ үзүүлсэн бүртгэл, баримттай	5, 4, 3 2, 0
3.	Байгууллагын гадаад, дотоод сүлжээ, түүний баяжилт, ашиглалт өргөжсөн байна.	3.1.Байгууллага нь гадаад сүлжээтэй (цахим хуудас, Facebook page гэх мэт), байнга баяжилт хийгддэг, ашигладаг байх	1. Цахим хуудас, Facebook page хуудаастай 2. Цэс, оруулсан мэдээллийн цаг хугацаа 3. Хандалтын тоо 4. Эрүүл мэндийн боловсрол олгох мэдээ, мэдээллийн төрөл 5. Хариуцсан ажилтантай	5, 4, 3 2, 0
		3.2.Байгууллагын ажилтнууд мэдээллээ түргэн шуурхай солилцдог дотоод сүлжээний үйл ажиллагаа хэвшсэн байх	1. Дотоод сүлжээнд холбогдсон, ашигладаг 2. Ямар, ямар мэдээлэл солилцож байгаа, ямар чиглэлд ямар зорилгоор ашиглаж байгааг болон үр дүнтэй байдлыг тодорхойлсон	5, 4, 3 2, 0
		3.3. Мэдээ, мэдээллийн нууцлалыг хадгалах нөхцлийг бүрдүүлсэн байх	1. Өвчний түүх болон үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлал, байгууллагын цахим мэдээллийн нууцыг хадгалах талаар зохицуулсан журамтай 2. Журмыг хэрэгжүүлж, баримт бичгийн нууцлалыг хадгалах нөхцөл, зохион байгуулалтыг хийсэн	5, 4, 3 2, 0
		3.4. Зайнаас /телемецина/ эмнэлзүйн зөвлөгөө авдаг тогтолцоог бүрдүүлсэн байх	1. Алсын зайнаас эмнэлзүйн зөвлөгөө авах үйл ажиллагааг зохицуулсан журамтай 2. Лавлагаа шатлалын байгууллагаас оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан бүртгэлтэй 3. Зайн сургалтанд хамрагддаг, бүртгэлтэй	5, 4, 3 2, 0
		3.5.Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилладаг байх	Дараах мэдээлэл ил тод байршсан байна: ○ Удирдлагын үйл ажиллагаа ○ Эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авдаг тусламж, үйлчилгээ	5, 4, 3 2, 0

			<ul style="list-style-type: none"> ○ Төсөв, түүний зарцуулалт ○ Хүний нөөцийн мэдээлэл ○ Зохион байгуулсан арга хэмжээний мэдээлэл ○ Эрүүл мэндийн үзүүлэлтүүд /чанар, аюулгүй байдлын/ ○ Сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт, эргэн мэдээлэл ○ Сайн туршлагын мэдээлэл 	
4.	Байгууллагын баримт бичгийн хөтлөлт жигдэрсэн байх	4.1.Хөтлөгдөх анхан шатны баримт бичгийн хөтлөлт, үг товчлол, тэмдэг, тэмдэглэгээг тодорхойлж, ашиглах заавар, зохицуулалтыг хийсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын баримт бичгийн хөтлөлтийг журамласан 2. Ажилтнуудад сургалт хийсэн, заавар, зөвлөгөө өгдөг 3. Баримт бичгийн хөтлөлтөд хяналт тавьдаг 	5, 4, 3 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

Дэд бүлэг 5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЗАСВАР, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журмыг мөрдөж ажиллана.	1.1. Төв нь тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журамтай, мөрддөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Багаж, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журмыг баталсан 2. Мөрдөлтөд хяналт тавьдаг 	5, 4, 3 2, 0
		1.2.Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг хийлгэх гэрээтэй ажилладаг 2. Гэрээнд тоног төхөөрөмжийн урьдчилсан үзлэг, техникийн үзлэг, засвар үйлчилгээний хуваарь, зардлыг тусгасан 3. Гэрээний биелэлтийг дүгнэдэг 4. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт жил бүр захиалга өгч, багаж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажилладаг 	5, 4, 3, 2, 0
2.	Тоног төхөөрөмжийн хангамж, бүртгэл мэдээллийн сантай байна.	2.1.Тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ, шалгалт тохируулгатай холбоотой мэдээллийн сантай ажилладаг 2. Мэдээллийн сангийн үйл ажиллагаа тогтмолжсон, аюулгүй байдлыг бүрэн хангасан 	5, 4, 3, 2, 0

		2.2.Тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлт хийдэг байх	1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээний хөрөнгийг төлөвлөж, байгууллагын төсөвт тусгасан 1. Шаардлагатай сэлбэг хэрэгслийн жагсаалт гаргасан 2. Солигдсон сэлбэг, хэрэгслийг баримтжуулсан 2. Санхүүгийн тайлантай 3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдол, насжилтийг тодорхойлдог	5, 4, 3, 2, 0
		2.3.Тоног төхөөрөмжийн хангамж, засвар, үйлчилгээтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж, арга хэмжээ авч ажилладаг байх	1. Тоног төхөөрөмжийн хангалт, засвар, үйлчилгээтэй холбоотой асуудлыг жил бүр нөхөрлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт өгдөг 2. Төхөөрөмжийн хангалт, засвар, үйлчилгээтэй холбоотой асуудлаар дээд шатны байгууллагад хандаж, шийдвэрлүүлсэн 3. Шийдвэрийн дагуу арга хэмжээ авч ажилладаг, үр дүнг тооцдог	5, 4, 3, 2, 0
3.	Тоног төхөөрөмжийн стандарт, удирдамж, зааврын дагуу чанар, аюулгүй ажиллагааг хангасан байна.	3.1.Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьдаг байх	1. Төвд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг боловсруулж, баталгаажуулсан 2. Аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг ажлын байранд байршуулсан 3. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтан бүрт өгдөг, гарын үсэг зуруулж баталгаажуулсан 4. Ашиглалт, аюулгүй ажиллагаанд тогтмол хяналт тавьдаг, хяналтын хуудас ашигладаг	5, 4, 3, 2, 0
		3.2.Тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах, аюулгүй ажиллагааны сургалтыг хийдэг байх	1. Тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах, аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөртэй 2. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтыг давтамжтайгаар хийдэг 3. Ажлын байр бүрийн тоног төхөөрөмжийг хариуцсан эмнэлгийн мэргэжилтэнд заавар, зөвлөгөө өгдөг 4. Сургалт хийсэн, заавар зөвлөгөө өгсөн бүртгэл хөтөлдөг 5. Ажлын байр бүрийг тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах, аюулгүй ажиллагааг хангах гарын авлагаар хангасан 6. Шинээр суурилуулсан тоног төхөөрөмжийн ашиглалт,	5, 4, 3, 2, 0

			ажиллуулах, аюулгүй ажиллагааны сургалтыг ажлын байран дээр хийсэн	
		3.3.Эмнэлгийн тоног төхөөрөмжинд шалгалт тохируулга хийлгэдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Шалгалт тохируулгад хамрагдах шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталсан 2. Шалгалт тохируулгад шаардлагатай зардлын тооцоо гаргаж, байгууллагын төсөвт суулгадаг 3. Журамд заасан хугацаанд тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийлгэдэг, үр дүнг тооцдог 4. Шалгалт тохируулгад тэнцээгүй тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулдаг арга хэмжээ авдаг 5. Шаардлагатай тоног төхөөрөмжийг баталгаажуулах гэрээг мэргэжлийн байгууллагатай хийсэн 6. Лабораторийн хэмжих хэрэгслүүд, цусны даралтын аппарат, даралтын монометр, термометр, жин зэрэг хэмжих хэрэгслүүдийг баталгаажуулсан 	5, 4, 3, 2, 0
		3.4.Эрсдэл өндөртэй тоног, төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Лабораторийн тоног төхөөрөмж бүрийн аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг, үйлчилгээ тохируулгыг тогтмол хийдэг 2. Хэвийн ажиллагааг өдөр бүр хянаж, тэмдэглэл хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0
		3.5.Тоног төхөөрөмжийн байршил зүй зохистой байх	<ol style="list-style-type: none"> 1. Нэг тоног төхөөрөмжид ноогдох талбай стандартад заасан хэмжээг хангасан 2. Өндөр даралтын ариутгалын тоног төхөөрөмжийн байршил, аюулгүй байдал зохих түвшинд байдаг 	5, 4, 3, 2, 0
		3.6.Тоног төхөөрөмж бүрийг газардуулгын системд холбож, аюулгүй ажиллагааг хангаж ажилласан байх	<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн байгууллагаар 2-оос доошгүй (өвөл, зун) удаа цэг тус бүр дээр газардуулгын хэмжилт хийлгэж, дүгнэлт гаргуулсан 2. Тоног төхөөрөмж бүр газардуулгад холбогдсон 3. Газардуулгын байршлын зураг гаргаж баталгаажуулсан 	5, 4, 3, 2, 0
4.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, засвар, үйлчилгээг хийдэг байна.	4.1.Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг төлөвлөгөө, графикийн дагуу хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Засвар үйлчилгээний баталсан төлөвлөгөөтэй, хэрэгжүүлдэг 2. Засвар үйлчилгээ хийхэд ашигласан сэлбэг, дагалдах хэрэгслийн бүртгэл хөтөлдөг 3. Засвар үйлчилгээний тайлантай 4. Засвар үйлчилгээний гарын авлага ашигладаг 	5, 4, 3, 2, 0

	4.2.Багаж,тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтыг тогтмол хөтөлдөг байх	1. Тоног төхөөрөмж бүрт техник ашиглалтын паспорттай 2. Техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтыг тогтмол, үнэн зөв хөтөлдөг 3. Ханган нийлүүлэгч байгууллагын суурилуулалт, засвар үйлчилгээний актыг хавсаргасан	5, 4, 3, 2, 0
	4.3.Тоног төхөөрөмжүүдэд техникийн үзлэг, үйлчилгээг тогтмол хийдэг байх	1. Тоног төхөөрөмжүүдэд техникийн үзлэг, үйлчилгээ хийх хуваарийг баталсан 2. Хуваарийн дагуу үзлэг, үйлчилгээг хийсэн 3. Үзлэг, үйлчилгээ хийсэн тухай тэмдэглэлийг техник ашиглалтын паспортад хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
	4.4.Тоног төхөөрөмжид тухай бүр засвар, үйлчилгээг хийдэг байх	1. Өндөр өртөгтэй, нарийн ажиллагаатай тоног төхөөрөмжид гадны байгууллагаар засвар үйлчилгээ хийлгэх гэрээтэй, баталгаажуулсан 2. Гэрээний хэрэгжилт акт, техник ашиглалтын паспорт хөтөлдөг 3. Тоног төхөөрөмжийн ажиллагаа, засвар үйлчилгээний тайлантай, холбогдох байгууллагад хүргүүлдэг 4. Шаардлагатай тоног төхөөрөмжид шалгалт, тохируулгыг хийлгэдэг	5, 4, 3, 2, 0
Онооны дүн	Авбал зохих оноо	...	
	Авсан оноо	...	

Дэд бүлэг 6. БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Байгууллага нь барилга, байгууламжийн орчны шаардлага болон инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг	1.1. Байгууллага нь барилга, инженерийн байгууламжийн байршил, бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан схем, зураглалтай байх	1. Барилга, инженерийн байгууламжийн байршил, бүрэлдэхүүн хэсэг /цахилгаан, сантехник, агааржуулагч, холбоо/ бүрийг харуулсан схем, зураглалтай, баталгаажуулсан 2. Барилга, инженерийн байгууламжийн үйл ажиллагаанд хийсэн үзлэг, шалгалт хийсэн тэмдэглэл, авсан арга хэмжээг баримтжуулсан	5, 4, 3, 2, 0

	хангаж ажилладаг байна.	1.2. Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянан шалгаж, сайжруулдаг тогтолцоо бүрдсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллага нь барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянан шалгаж, арга хэмжээ авах батлагдсан төлөвлөгөөтэй 2. Төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьдаг 3. Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаанд үзлэг, шалгалтыг тогтмол хийдэг 4. Үзлэг, шалгалт хийх хуудсыг боловсруулж ашигладаг 5. Үзлэг, шалгалтын дүгнэлт, авсан арга хэмжээний талаар тэмдэглэл хөтөлж, баримтжуулсан 	5, 4, 3, 2, 0
		1.3. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор гадны байгууллагаар гүйцэтгүүлэх инженерийн үйлчилгээг хийж гүйцэтгүүлдэг гэрээтэй байх	<ol style="list-style-type: none"> 1. Ус, цахилгаан, дулаан хангамж, агааржуулалтын систем, сантехник зэрэг инженерийн үйлчилгээ, засварыг гүйцэтгүүлэх гэрээг холбогдох байгууллага тус бүртэй байгуулсан, баталгаажуулсан 2. Гэрээнд заасан дагуу үзлэгийг хийж, бүртгэл, тэмдэглэл хөтөлдөг 3. Гэрээний гүйцэтгэлийг жил бүр хянадаг 	5, 4, 3, 2, 0
		1.4. Байгууллагын гадаад орчин, барилга байгууламж нь эрүүл ахуйн шаардлага хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Орчноос тусгаарласан хашаатай, хаягжуулсан 2. Байгууллагын хашаанд үйлчлүүлэгчид тав тухтай байдлыг хангах ногоон байгууламжтай, зүлэгжүүлсэн, зам талбайг цардаж тохижуулсан, сүүдрэвч, сандалтай 3. Гадна орчныг бүхэлд нь гэрэлтүүлэх гэрэлтүүлэгтэй 4. Тэргэнцэртэй иргэдэд зориулсан бариул бүхий налуу замтай 5. Машины зогсоолтой 	5, 4, 3, 2, 0
2.	Усан хангамж болон цахилгааны нөөцийг бүрдүүлж, хэвийн ажиллагааг хангана.	2.1. Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгэвэртэй байх	<ol style="list-style-type: none"> 1. Цахилгааны нөөц үүсгэвэртэй, ажиллагааг тогтмол хянадаг 2. Цахилгааны нөөц үүсгэвэр нь байгууллагын хэмжээнд тусламж, үйлчилгээг хэвийн явуулах хүчин чадалтай 3. Сэлгэн залгалтын хэвийн ажиллагааг сар тутамд зохих мэргэжлийн байгууллагатай хамтарч хянадаг, баримтжуулсан 	5, 4, 3, 2, 0
		2.2. Цахилгааны нөөц тэжээлийн найдваржилт хангагдсан байх	<ol style="list-style-type: none"> 1. АВР /Автомат сэлгэн залгагч/-ийн ажиллах техник болон схем зурагтай 2. Нөөц тэжээлийн хүчин чадал нь тухайн байгууллагын тоног төхөөрөмжүүдийн суурилагдсан хүчин чадлаас багагүй 3. Нөөц тэжээлийн сэлгэн залгалтын шуурхай ажиллагаа, 	5, 4, 3, 2, 0

			найдваржилтыг хангаж буйг мэргэжлийн байгууллага зохих туршилтаар баталгаажуулсан	
		2.3.Цахилгаан энергийн чанарын шаардлагад нийцсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Стандартад нийцсэн эсэхийг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хэмжилт, туршилт хийлгэж цахилгаан тэжээлийн чанарыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авсан 2. Хэмжилт хийх цэгүүдийг цахилгаан энергийн чанар доголдож болзошгүй /мэдрэмтгий/ хэрэглэгчид хийлгэх /ЭКГ, ЭХО, сэргээн засах эмчилгээний аппарат/ 3. Цахилгаан энергийн чанарыг доголдуулж болзошгүй /шугаман бус/ хэрэглэгчийн (сэргээн засах эмчилгээний аппарат) 4. Бүлэг хэрэглэгчид, оролт дээр хэмжилт туршилт хийдэг 	5,4, 3, 2, 0
		2.4.Байгууллагын хангамжийн тасралтгүй байх усан үйлчилгээ	<ol style="list-style-type: none"> 1. 24 цагийн усан хангамжтай 2. Усны тасалдал гарсан тохиолдолд зохицуулах арга хэмжээг төлөвлөсөн 3. Ундны усны шинжилгээтэй, шаардлага хангасан 	5,4, 3, 2, 0
3.	Даралтат сав болон агааржуулалтын системийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.	3.1.Даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч тэмдэглэл хөтөлдөг, хяналт авдаг 2. Даралтат савыг баталгаажуулсан 3. Даралтат савыг хаягжуулж, бэхэлгээ хийсэн 4. Даралтат сав /баллон/-ыг зөөвөрлөх бэхэлгээтэй тэргэнцэр эсвэл тусгай зориулалтын тээвэрлэх хэрэгсэлтэй 5. Даралтат савыг ажиллуулах бичмэл заавартай 6. Даралтат савын ажиллуулсан үед тэмдэглэгээ хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0
		3.2.Агааржуулалтын хэвийн үйл ажиллагааг хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Агааржуулалтын хоолойн агаарт (халдваргүйжүүлэлт) бактериологийн шинжилгээ хийлгэсэн 2. Агааржуулалтын фильтр (шүүлтүүр)-ыг зохих шаардлагын дагуу сольж, үйлчилгээ хийлгэсэн 3. Агааржуулагчийн филтросолих, халдваргүйжүүлэх, урсгал засварын ажлыг орчин үеийн шаардлагын түвшинд хийсэн 	5,4, 3, 2, 0
4.	Галын аюулгүй байдлыг хангаж ажиллана	4.1. Галын аюулгүй байдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтад хамруулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын хэмжээнд мөрддөг галын аюулгүй ажиллагааны батлагдсан заавартай, мөрддөг 2. Харьяалах нутаг дэвсгэрийн Онцгой байдлын газар/хэлтэстэй хамтран ажилтнуудад жилд 1-2 удаа галын 	5, 4, 3, 2, 0

		аюулгүй байдлын дадлага сургалтыг зохион байгуулж, баримтжуулсан	
		3. Галын аюулаас урьдчилан сэргийлэх буланг шаардлагатай цэгүүдэд байршуулсан 4. Гал унтраах хэрэгслийг ашиглах зааврыг өгдөг	
	4.2. Гал гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах тусгай тэмдэг бүхий гарц, схем зураглалтай байх	1. Аврах гарцын схем, тэмдэг тэмдэглэгээнүүдийг шаардлагатай цэгүүдэд байршуулсан 2. Гал унтраах бүлгэмтэй 3. Гал унтраах хэрэгслээр хангасан, шаардлагатай цэгүүдэд байршуулсан	5,4, 3, 2, 0
	4.3.Галын аюулын үед сэрэмжлүүлэх дуудлагын болон дохиоллын хэрэгслээр хангасан байх	1. Галын аюулгүй байдлын үед ашиглах дуут дохио, холбоо хэрэгслээр хангасан 2. Аваарын гэрэлтүүлэгтэй	5, 4, 3, 2, 0
	4.4.Галын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх	1. Харьяа аймаг, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтсээс жил бүр дүгнэлт гаргуулсан	5,4, 3, 2, 0
	4.5.Галын хорыг шаардлагатай өрөө, нэгжид зохих журмын дагуу байрлуулж, хорыг цэнэглэсэн ба ашигласан бүртгэлийг хөтөлдөг байх	1. Галын хорын тоог гаргаж, бүртгэлжүүлсэн 2. Шаардлагатай цэгүүдэд галын хорыг байршуулсан 3. Мэргэжлийн байгууллагатай гэрээтэй ажиллаж, цэнэглүүлсэн баримттай 4. Галын хорыг цэнэглэсэн ба ашигласан бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн 5. Техник ашиглалтын паспорт хөтөлсөн тэмдэглэлтэй 6. Галын хорыг худалдан авсан, цэнэглэсэн санхүүгийн баримттай	5,4, 3, 2, 0
Онооны дүн	Авбал зохих оноо	...	
	Авсан оноо	...	

**БҮЛЭГ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

I. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Нийгмийн эрүүл мэнд /НЭМ/-ийн талаар баримтлах бодлого, чиглэл, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	1.1.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг хангасан байх	1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, стратеги бүрийн хүрээнд өөрийн байгууллагад хамаарах зорилго, зорилт, үйл ажиллагааг тусгасан төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлдэг 2. Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлан, дүгнэлттэй ажилладаг 3. Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч хамтран ажилладаг, тайлантай 4. Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг дүгнэдэг, үзүүлэлтүүдийн тоо, хувь нь жил бүр нэмэгдсэн	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.2.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг жил бүр төлөвлөн үр дүнг тооцдог байх	1. НЭМ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зардал, үр дүн 2. НЭМ-ийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангахад чиглэсэн санхүүжилт, үр дүн	5, 4, 3, 2, 0
		1.3.НЭМ-ийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж ажилладаг байх	1. Хэрэгжүүлж байгаа НЭМ-ийн үндэсний хөтөлбөр, стратегиудийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, дүгнэлт өгдөг 2. Тайлантай, гарсан үр дүнг тооцсон	5, 4, 3, 2, 0
		1.4.Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж, үр дүнг тооцсон байх	1. Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн тархалтын хандлагыг тодорхойлж, тандалт судалгаа хийдэг 2. Судалгааны тайлантай 3. Авсан арга хэмжээний үр дүнг тооцдог	5, 4, 3, 2, 0
		1.5.Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион	1. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааг хийдэг 2. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний	5, 4, 3, 2, 0

		байгуулдаг байх	бүртгэл, судалгаатай 3. Халдварт бус өвчний эрсдэлт бүлгийн судалгааг гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг	
		1.6.Халдварт өвчин гарахад нөлөөлөх хүчин зүйлийг судалж, эрсдлээс сэргийлэх чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажилладаг байх	1. Халдварт өвчин гарахад нөлөөлөх хүрээлэн буй орчны эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, эрсдлээс сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тодорхой ажлууд хийсэн, тайлантай 2. Халдварт өвчнөөс сэргийлж заавал хийх, нөхөн, нэмэлт, тархвар судлалын заалтаар болон сайн дурын дархлаажуулалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон	5, 4, 3, 2, 0
		1.7.Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа хийдэг байх	1. Хүн амыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулдаг 2. Халдварт өвчинд өртөх эрсдэлт бүлгийн судалгааг гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг 3. Халдварт өвчний тохиолдол аймаг, нийслэл, улсын дундажаас доогуур, эсхүл өмнөх жилийн үзүүлэлтээс буурсан 4. Цочмог халдварт өвчин гарсан тохиолдолд голомтын арга хэмжээг шуурхай авч, тархалтаас сэргийлсэн 5. Тандалт судалгааны тайлан, дүгнэлттэй 6. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд иргэдийг хамруулж, бүртгэлтэй ажилладаг	5, 4, 3, 2, 0
		1.8.Шинэ болон шинээр сэргэн тархаж байгаа халдвар, томуу, томуу төст өвчин, зоонозын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байх	1. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвар, томуу, томуу төст өвчин, зоонозын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа хийдэг 2. Дээрх чиглэл бүрээр хийсэн ажлын тайлантай	5, 4, 3, 2, 0
2.	Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	2.1.Хүн амын бүртгэл, мэдээллийг шинэчлэн хөтөлж, баяжилт хийдэг байх	1. Өөрийн харъяаллын хүн амын бүртгэл, мэдээллийг жил бүр шинэчлэн хөтөлж, баяжилт хийдэг 2. Мэдээлэлд үндэслэн тусламж, үйлчилгээг зохион байгуулалтад ашигладаг 3. Бүртгэл, мэдээлэлтэй холбоотой анхан шатны бүртгэлийн маягтуудын хөтөлдөг	5, 4, 3, 2, 0

		2.2.Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлэгт үнэлгээ, дүгнэлт хийж, хяналт тогтоох, цаашид авах арга хэмжээг төлөвлөдөг байх	1. Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлэгт жил бүр үнэлгээ, дүгнэлт хийдэг 2. Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн хяналт тогтоох, цаашид авах арга хэмжээг төлөвлөдөг 3. Авсан арга хэмжээний үр дүнг тооцдог 4. Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлгийн үнэлгээ хийсэн бүртгэл, анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлдөг 5. Тайлантай	5, 4, 3, 2, 0
		2.3.Өөрийн харъяаллын хүн амын өвчлөлийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлдог байх	1. Жил бүр зонхилон тохиолдох өвчин эмгэгийн тархалтын хандлагыг тодорхойлох, тандалт судалгаа хийсэн 2. Судалгааны дүгнэлтэд үндэслэн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн 3. Судалгааны тайлантай 4. Авсан арга хэмжээний үр дүнг тооцдог	5, 4, 3, 2, 0
		2.4.Иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх халдварт өвчний хүчин зүйлийн тандалтыг хийдэг байх	1. Халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж, үр дүнг тооцдог 2. Халдварт өвчнийг бууруулах арга хэмжээ авдаг 3. Халдварт өвчин буурсан үзүүлэлттэй	5, 4, 3, 2, 0
		2.5.Халдварт бус өвчин үүсэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийдэг байх	1. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх тандалт судалгаа хийдэг 2. Судалгааны тайлан дүгнэлттэй, үр дүнг тооцсон 3. Халдварт бус өвчнийг бууруулах арга хэмжээ авсан тайлантай 4. Халдварт бус өвчин буурсан үзүүлэлттэй	5, 4, 3, 2, 0
3.	Дархлаажуулалтыг товллын дагуу зохион байгуулсан байна.	3.1.Дархлаажуулалт хийх нөхцөл, шаардлагыг хангасан байх	1. Орон тоогоор болон орлон ажиллах сувилагчийг сургаж, бэлтгэсэн 2. Дархлаажуулалт хийх эрүүл ахуйн шаардлага хангасан өрөөтэй 3. Вакцин хадгалах зориулалтын хөргөгч /тог баригчтай/, хэм хяналтын хэрэгслүүдтэй	5, 4, 3, 2, 0
		3.2.Хамарвал зохих хүүхдийг товлот дархлаажуулалтанд бүрэн	1. Дархлаажуулалтыг товллын дагуу хийдэг /тавт вакцин, улаан бурхан, гахайн хавдар, улаанууд,	5, 4, 3, 2, 0

		хамруулсан байх	улаануудын эсрэг вакцины хамралт/ 2. Хүрч үйлчлэхэд бэрхшээлтэй өрхийн хүүхдийг дархлаажуулалтанд хамруулсан, бүртгэлтэй 3. Нөхөн дархлаажуулалтад хамруулсан бүртгэл, судалгаатай 4. Дархлаажуулалтыг зохион байгуулсан тайлан, дүгнэлттэй 5. Дархлаажуулалтын үзүүлэлтийг улс, аймаг, нийслэлийн дундаж үзүүлэлт болон “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тоо, хэмжээ, чанарын үзүүлэлт”-тэй харьцуулсан дүгнэлттэй	
4.	Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг байна.	4.1.Хувь хүн, байгууллага, хамт олон, үйлчлүүлэгчид чиглэсэн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулдаг байх	1. Эрүүл иргэн, өрх гэр, эрүүл ажлын байр, эрүүл хамт олон, эрүүл орчин бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагааа зохион байгуулан, үр дүнг тооцон ажилласан 2. Албан байгууллага, аж ахуйн нэгжийг эрүүл мэндийг дэмжигч байгууллага болоход мэргэжлийн арга зүйгээр хангадаг 3. Архи, тамхигүй орчин бүрдүүлэх, архины зохисгүй хэрэглээг сурталчилдаг 4. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэх, үр дүнг тооцон, ахиц гарсан	5, 4, 3, 2, 0
		4.2.Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж ажилладаг байх	1. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр орон нутгийн удирдлага, албан байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний дэмжлэгийг авдаг 2. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд иргэд, байгууллага, эрүүл мэндийн сайн дурын идэвхтнүүдийг оролцуулдаг 3. Эрүүл мэндийн сайн дурын идэвхтнийг эрүүл мэндийг дэмжих чиглэлээр жил бүр бэлтгэдэг, давтан сургаж, хамтран ажилладаг	5, 4, 3, 2, 0
		4.3.Хувь хүний чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажилладаг байх	1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хувь хүний чадварыг хөгжүүлэх арга, дадлыг сургах арга хэмжээ авдаг 2. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийн асран хамгаалагчдад дадал эзэмшүүлэх ажлыг зохион байгуулсан	5, 4, 3, 2, 0

		4.4.Хүн амын дунд дасгал хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийг хийдэг байх	1. Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх өрөөг стандартын дагуу зохион байгуулж, тоног төхөөрөмжөөр хангасан 2. Дасгал хөдөлгөөний жортой, дасгал хөдөлгөөнийг зааж сургадаг	5, 4, 3, 2, 0
		4.5.Сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж, хүүхдийн өсөлт, хөгжлийг үнэлэх, биеийн индексийг тодорхойлох болон амны хөндий гүйлсэн булчирхай, харааны эмгэгийг ирүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулдаг байх	1. Сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж, хамтран ажилладаг 2. Хүүхдийн өсөлт, хөгжлийг үнэлэх, биеийн индексийг тодорхойлж, дүгнэлт өгч, холбогдох арга хэмжээ авсан 3. Хүүхдийн харааны эмгэгийг ирүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй хамтран хийсэн, үр дүн гарсан 4. Хүүхдийн харааны эмгэгийг ирүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийн мэдээ, тайлантай	5, 4, 3, 2, 0
5.	Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааг календарчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг байна.	5.1.Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа /МСС/-ны хөтөлбөр /төлөвлөгөө/-тэй, хэрэгжүүлдэг байх	1. Иргэдэд эрүүлмэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааны батлагдсан төлөвлөгөөтэй 2. Төлөвлөгөөний дагуу мэдээлэл, сургалт, сурталчилгааг явуулдаг, тайлантай 3. Сургалтын үр дүнгийн судалгаатай 1. Мэдээлэл сургалт сурталчилгааны материал, гарын авлагатай, тогтмол баяжуулж, ашигладаг	5, 4, 3, 2, 0
		5.2.Зонхилон тохиолдох өвчин эмгэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа /МСС/-г тогтмол хийдэг байх	1. Зонхилон тохиолдох өвчин эмгэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр МСС-ны хийдэг 2. МСС-ны төрөл, хэвлүүлсэн МСС-ны материалын төрөл, тоо 3. МСС хийсэн бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
		5.3.Үйлчлүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөлөөр хангасан байх	1. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт явуулах өрөөтэй, шаардлагатай хэрэгслээр хангасан 2. Ганцаарчилсан зөвлөгөө авах нөхцөлийг хангасан 3. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудыг сургадаг 4. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх видео, үзүүлэн, гарын авлага, материалаар хангасан 5. Тухайн жилд шинээр бэлтгэсэн МСС-ны материалын тоо,	5, 4, 3, 2, 0

			<p>төрөл</p> <p>6. Тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан чиглэлээр зорилтод бүлэгт зөвлөгөө өгдөг, тайлантай</p>	
		5.4.Хүлээлгийн танхимуудад МСС-г тасралтгүй явуулдаг байх	<p>1. Хүлээлгийн танхимуудад МСС явуулах хэрэгсэлтэй, тогтмол явуулдаг</p> <p>2. Хариуцсан ажилтантай</p> <p>3. Үйлчлүүлэгчийг гарын авлага, материалаар хангасан</p>	5, 4, 3, 2, 0
		5.5.Иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулсан байх	<p>1. Халдварт бус өвчнөөс сэргийлэх /архи, тамхи, мансууруулах бодисыг хэрэглэх буруу зан үйлийг өөрчлөх, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн хийх/ эрүүл зан үйл төлөвшүүлэх чиглэлээр хийсэн ажил, гарсан үр дүн</p> <p>2. Халдварт өвчнөөс сэргийлэх /БЗДХ, ХДХВ, сүрьеэ/ болон бусад чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн</p> <p>3. Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олгох, жирэмслэлтээс сэргийлэх аргад сургах чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн</p> <p>4. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн</p> <p>5. Эрүүл, зөв зохистой хооллолтыг дэмжих чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн</p>	5, 4, 3, 2, 0
		5.6. Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг хийдэг байх	<p>1. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах талаар сургалт, сурталчилгаа хийдэг</p> <p>2. Үе тэнгийн сургагч багш, сайн дурын идэвхтэн бэлтгэдэг</p> <p>3. Үе тэнгийн сургагч багш, сайн дурын идэвхтэний тоо жил бүр нэмэгдэж, үйл ажиллагаа тогтмолжсон</p>	5, 4, 3, 2, 0
6.	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулж үр дүн гарсан байна.	6.1.Урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	<p>1. Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амыг насны ангиллаар жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг</p> <p>2. Үзлэгээр өвчин эмгэг илэрсэн тохиолдолд холбогдох удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу дээд шатны байгууллагад шилжүүлэх, оношлох, эмчлэх, хянах, эргэн мэдээлж ажилладаг</p> <p>3. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй</p> <p>4. Урьдчилан сэргийлэх үзлэгийг хувь жил бүр нэмэгдсэн</p> <p>5. Эрүүл мэндийн нэг, хоёрдугаар бүлгийн иргэдийн 80%-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан</p> <p>6. Хүн амыг тэмбүү, сүрьеэ өвчний илрүүлэг үзлэгт</p>	5, 4, 3, 2, 0

		хамруулсан хувь 7. Эмчлэн эрүүлжүүлсэн, хяналтад авсан үйлчлүүлэгчийн тоо, хувь	
	6.2. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлдэг байх	1. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг 2. Шүд цоорох болон бусад өвчин эмгэгтэй илэрсэн хүүхдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хийдэг 3. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан хүүхдийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй 4. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь жил бүр нэмэгдсэн 5. Эмчлэн эрүүлжүүлсэн, хяналтад авсан үйлчлүүлэгчийн тоо, хувь	5, 4, 3, 2, 0
	6.3. Артерийн даралт ихсэлтийн эрт илрүүлэг үзлэгийг хийж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	1. Тухайн жилд хамрагвал зохих зорилтот бүлгийн иргэдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувь 2. Эмчилгээнд хамруулсан хүний тоо/ хувь 3. Зохистой түвшинд хянагдаж байгаа хүний тоо/ хувь 4. Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилж, хянадаг 5. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 6. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй 7. Артерийн даралт ихсэлт өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн	5, 4, 3, 2, 0
	6.4. Чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгийг хийж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	1. Тухайн жилд хамрагдвал зохих зорилтот бүлгийн иргэдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувь 2. Эмчилгээнд хамруулсан хүний тоо/ хувь 1. Зохистой түвшинд хянагдаж байгаа хүний тоо/ хувь 2. Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилж, хянадаг 3. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын	5, 4, 3, 2, 0

		байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 4. Чихрийн шижин өвчний илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй	
	6.5.Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	1. Тухайн жилд хамрагдвал зохих зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувь 2. Эмчилгээнд хамруулсан хүний тоо/ хувь 3. Зохистой түвшинд хянагдаж байгаа эмэгтэйчүүдийн тоо/ хувь 4. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлааа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 5. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн 6. Хавдрын эрт шатанд оношилсон, эмчилсэн хувь нэмэгдсэн 7. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй	5, 4, 3, 2, 0
	6.4.Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгүзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	1. Тухайн жилд хамрагдвал зохих эмэгтэйчүүдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувь 2. Эмчилгээнд хамруулсан эмэгтэйчүүдийн тоо/ хувь 3. Зохистой түвшинд хянагдаж байгаа эмэгтэйчүүдийн тоо/ хувь 4. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 5. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн 6. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй	5, 4, 3, 2, 0
	6.5.Элэг, улаан хоолой, ходоод, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	1. Элэг, улаан хоолой, ходоод, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг тус бүрд тухайн жилд хамруулсан зорилтот бүлгийн иргэдийн тоо /хувь 2. Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилгээ, хяналтыг явуулдаг	5, 4, 3, 2, 0

			<ul style="list-style-type: none"> 3. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлэх, хянах, эргэн мэдээлдэг 4. Элэг, улаан хоолой, ходоод, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн 5. Хавдрын эрт шатанд оношилсон, эмчилсэн хувь нэмэгдсэн 6. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэлтэй /анхан шатны бүртгэлийн маягт/ 	
		6.6.Зүрхний архаг дутагдлын болон дислипидемийн эрт илрүүлэг хийдэг байх	<ul style="list-style-type: none"> 1. Зүрхний архаг дутагдлын эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо/ хувь 2. Дислипидемийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо/ хувь 3. Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилж, хянасан 4. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 5. Үзлэгийн бүртгэл, эмчилсэн, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэлтэй /анхан шатны бүртгэлийн маягт/ 	5, 4, 3, 2, 0
		6.7.Эрт илрүүлэг үзлэгийн хувь, үзүүлэлт өмнөх жилээс нэмэгдсэн байх	<ul style="list-style-type: none"> 1. Умайн хүзүү, хөх, элэгний хорт хавдрын, артерийн даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгийн хувь өмнөх жилээс нэмэгдсэн 2. Хорт хавдрыг эрт үед оношилсон хувь нэмэгдсэн 3. Илрүүлэг үзлэг тус бүрийн хувь аймаг, нийслэл, дүүргийн дундаж үзүүлэлтээс өндөр байх 	5, 4, 3, 2, 0
7.	Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байна.	7.1.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэлтэй, жил бүр баяжилт хийж, урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулсан байх	<ul style="list-style-type: none"> 1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэлтэй, жил бүр баяжилт хийдэг 2. Эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан бүртгэл, судалгаатай 3. Хяналтанд авч, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авдаг 	5, 4, 3, 2, 0
		7.2.Эмэгтэйчүүдийг хөхөө шалгах аргад сургасан байх, бүртгэлтэй байх	<ul style="list-style-type: none"> 1. Хөхөө шалгах аргад сургасан эмэгтэйчүүдийн бүртгэлтэй 2. Сургалтын үзүүлэн, гарын авлагатай 3. Хамрагдалтын хувь 	5, 4, 3, 2, 0
		7.3.Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олгох, жирэмслэхээс сэргийлэх аргад сургах ажлыг	<ul style="list-style-type: none"> 1. Эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа хийдэг 2. Жирэмслэхээс сэргийлэх аргад сургадаг 	5, 4, 3, 2, 0

		зохион байгуулсан байх	3. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэтэйчүүдийн судалгаатай, дүгнэлт өгдөг 4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээний хувь 5. Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн нөөцтэй	
Онооны дүн	Авбал зохих оноо		...	
	Авсан оноо		...	

II.ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ				
1.	Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг хийсэн байна.	1.1.Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр батлагдсан бодлого, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлдэг байх	1. Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний бодлого, үндэсний хөтөлбөрийн холбогдох зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан 2. Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэдэг, тайлантай 3. Батлагдсан журам, дүрмийн хэрэгжилт, тайлан, дүгнэлт, үр дүнг дүгнэдэг	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.2.Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхамыг бодлогын баримт бичигтээ тусган хэрэгжүүлдэг байх	1. Өөрийн байгууллагын баталсан баримт бичигт эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-аас хамгийн багадаа “8 алхам”-ыг тусгасан 2. Ажлын байранд ашиглаж байгаа удирдамж, заавартай 3. Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлантай 4. Ажилтны ажлын гүйцэтгэлд хийсэн үнэлгээ, хэрэгжилтийн хувь	5, 4, 3, 2, 0
		1.3.Нярайн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт) зэргийг худалдаалах, ханган нийлүүлэх болон үнийн хямдрал, хөнгөлөлт тусгай урамшуулал өгөхийг хориглосон байх	1. “Нялх,балчир хүүхдийн хүнсний тухай хууль”-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлдэг 2. Байгууллага доторнярайн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт) зэргийг худалдаалдаггүй 3. Авсан арга хэмжээ, үр дүн, гүйцэтгэлтэй	5, 4, 3, 2, 0

		1.4.Нярайн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт)-ийн үйлдвэрлэгчийн лого, зураг, дүрс зар сурталчилгааг байрлуулахгүй байх	1. Байгууллага дотор нярайн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт)-ийн үйлдвэрлэгчийн лого, зураг, дүрс зар сурталчилгааг байрлуулаагүй	5, 4, 3, 2, 0
		1.5.Эмч, сувилагч нарыг нярайн эрт үеийн болон эх барихын нэн шаардлагатай тусламжийн сургалтанд хамруулсан байх	1. Сургалтын хөтөлбөр, сургалтанд хамруулсан бүртгэл, гэрчилгээ, бусад баримттай 2. Зохион байгуулсан арга хэмжээний тайлантай	5, 4, 3, 2, 0
		1.6.Нийт ажилтнууд нярай хүүхдийг эхийн сүүгээр хооллох чиглэлээр сургалтанд хамрагдсан байх	1. Сургалтын тайлан (Сургалтад хамрагдсан ажилтны бүртгэл, гэрчилгээ, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр г.м)-тэй 2. Сүүлийн 2 жилд сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо/хувь	5, 4, 3, 2, 0
		1.7.Эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн эрхзүйн баримт бичгийг эрүүл мэндийн ажилтнуудад танилцуулах сургалт хийсэн, ажилтнууд мэддэг байх	1. Танилцуулах сургалтын төлөвлөгөө, хамрагдсан ажилтнуудын бүртгэл, сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо/хувь, 2. Сургалтын тайлантай	5, 4, 3, 2, 0
		1.8.Ажлаа хийж байгаа эхчүүд хүүхдээ хөхүүлэх орчин бүрдүүлж, дэмжлэг үзүүлж ажилладаг байх	1. Ажилчдад зориулсан хүүхэд хөхүүлэх өрөөтэй, тав тухтай, тохижуулсан 2. Ажлын цаг, ачааллыг зохицуулсан	5, 4, 3, 2, 0
2.	Жирэмсний хяналтыг сайжруулж, хүндрэлээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.	2.1.Жирэмсэн эхийг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд хамруулсан хувь өмнөх оноос нэмэгдсэн байх	1. Жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 93% ба түүнээс дээш 2. Аймаг, нийслэл, улсын дундаж үзүүлэлттэй харьцуулан үнэлж дүгнэдэг, сайжруулах арга хэмжээ авсан	5, 4, 3, 2, 0
		2.2.Жирэмсний хяналтыг удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг байх	1. Эмч, сувилагч нар нь сургагдсан /эх баригч/ 2. Жирэмсний хяналтыг холбогдох журам, удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг 3. Жирэмсэн эхийг 100% хяналтанд авсан 4. Шилжих хөдөлгөөн хийгдсэн жирэмсэн эхчүүдийн бүртгэлтэй 5. Эхчүүдэд жирэмсний хяналтын талаар зөвлөгөө өгдөг	5, 4, 3, 2, 0

2.	Тоног төхөөрөмжийн хангамж, бүртгэл мэдээллийн сантай байна.	2.1.Тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлсэн байх	1. Тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ, шалгалт тохируулгатай холбоотой мэдээллийн сантай ажилладаг 2. Мэдээллийн сангийн үйл ажиллагаа тогтмолжсон, аюулгүй байдлыг бүрэн хангасан	5, 4, 3, 2, 0
		2.2.Тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлт хийдэг байх	1. Тоног төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээний хөрөнгийг төлөвлөж, байгууллагын төсөвт тусгасан 1. Шаардлагатай сэлбэг хэрэгслийн жагсаалт гаргасан 2. Солигдсон сэлбэг, хэрэгслийг баримтжуулсан 2. Санхүүгийн тайлантай	5, 4, 3, 2, 0

			3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдол, ашиглалтын хугацааг тодорхойлдог	
		2.3.Тоног төхөөрөмжийн хангамж, засвар, үйлчилгээтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж арга хэмжээ авч ажилладаг байх	1. Тоног төхөөрөмжийн хангалт, засвар, үйлчилгээтэй холбоотой асуудлыг жил бүр удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, дүгнэлт өгдөг 2. Төхөөрөмжийн хангалт, засвар, үйлчилгээтэй холбоотой асуудлаар дээд шатны байгууллагад хандаж, шийдвэрлүүлсэн 3. Шийдвэрийн дагуу арга хэмжээ авч ажилладаг, үр дүнг тооцдог	5, 4, 3, 2, 0
3.	Тоног төхөөрөмжийн стандарт, удирдамж, зааврын дагуу чанар, аюулгүй ажиллагааг хангасан байна.	3.1.Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьдаг байх	1. Бүх тасаг/нэгжид байгаа тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг боловсруулж, баталгаажуулсан 2. Аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг ажлын байранд байршуулсан 3. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтан бүрт өгдөг, гарын үсэг зуруулж баталгаажуулсан 4. Ашиглалт, аюулгүй ажиллагаанд тогтмол хяналт тавьдаг, хяналтын хуудас ашигладаг	5, 4, 3, 2, 0
		3.2.Тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах, аюулгүй ажиллагааны сургалтыг хийдэг байх	1. Тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах, аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөртэй 2. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтыг давтамжтайгаар хийдэг 3. Ажлын байр бүрийн тоног төхөөрөмжийг хариуцсан эмнэлгийн мэргэжилтэнд заавар, зөвлөгөө өгдөг 4. Сургалт хийсэн, заавар зөвлөгөө өгсөн бүртгэл хөтөлдөг 5. Ажлын байр бүрийг тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах, аюулгүй ажиллагааг хангах гарын авлагаар хангасан 6. Шинээр суурилуулсан тоног төхөөрөмжийн ашиглалт, ажиллуулах, аюулгүй ажиллагааны сургалтыг ажлын байран дээр хийсэн	5, 4, 3, 2, 0
		3.3.Эмнэлгийн тоног төхөөрөмжинд шалгалт тохируулга хийлгэдэг байх	1. Шалгалт тохируулгад хамрагдах шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталсан 2. Шалгалт тохируулгад шаардлагатай зардлын тооцоо гаргаж, байгууллагын төсөвт суулгадаг	5, 4, 3, 2, 0

			<ol style="list-style-type: none"> 3. Журамд заасан хугацаанд тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийлгэдэг, үр дүнг тооцдог 4. Шалгалт тохируулгад тэнцээгүй тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулдаг арга хэмжээ авдаг 5. Шаардлагатай тоног төхөөрөмжийг баталгаажуулах гэрээг мэргэжлийн байгууллагатай хийсэн 6. Лабораторийн хэмжих хэрэгслүүд, цусны даралтын аппарат, даралтын монометр, термометр, жин зэрэг хэмжих хэрэгслүүдийг баталгаажуулсан 	
		3.4.Эрсдэл өндөртэй тоног, төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Мэс заслын, лабораторийн тоног төхөөрөмж бүрийн аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг, үйлчилгээ тохируулгыг тогтмол хийдэг 2. Хэвийн ажиллагааг өдөр бүр хянаж, тэмдэглэл хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0
		3.5.Тоног төхөөрөмжийн байршил зүй зохистой байх	<ol style="list-style-type: none"> 1. Нэг тоног төхөөрөмжид ноогдох талбай стандартад заасан хэмжээг хангасан 2. Өндөр даралтын ариутгалын тоног төхөөрөмжийн байршил, аюулгүй байдал зохих түвшинд байдаг 	5, 4, 3, 2, 0
		3.6.Тоног төхөөрөмж бүрийг газардуулгын системд холбож, аюулгүй ажиллагааг хангаж ажилладаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн байгууллагаар 2-оос доошгүй (хавар, намар) удаа цэг тус бүр дээр газардуулгын хэмжилт хийлгэж, дүгнэлт гаргуулсан 2. Тоног төхөөрөмж бүр газардуулгад холбогдсон 3. Газардуулгын байршлын зураг гаргаж баталгаажуулсан 	5, 4, 3, 2, 0
4.	Эрүүл мэндийн байгууллагад ашиглаж буй рентген тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангасан байна.	4.1.Цацрагийн үүсгүүртэй рентген тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Цацрагийн үүсгүүртэй рентген тоног төхөөрөмжийг ашиглах тусгай зөвшөөрөлтэй 2. Өрөө тасалгаа, тоног төхөөрөмжид цацрагийн тунгийн хэмжилтийг тогтмол хийлгэсэн 3. Цацрагийн болон рентген тоног төхөөрөмжийн туяаны тун зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд цацрагийн хяналтын газар болон бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлттэй 4. Албадмал салхилуурын системээр хангасан (рентген) 5. Хамгаалах хувцас хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьдаг 	5, 4, 3, 2, 0
		4.2. Рентген туяаны хор нөлөөнөөс сэргийлэх арга хэмжээ авдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Цацрагтай орчинд ажиллагсдын хувийн дозиметрийг сар бүр хэмжилтэнд хамруулдаг 2. Эмнэлгийн мэргэжилтэн, техникийн ажилтнуудыг 	5, 4, 3, 2, 0

			цацрагаас хамгаалах хувцас, хэрэгслээр хангасан, хэрэглэж хэвшсэн 3. Үйлчлүүлэгчид зориулсан цацрагаас хамгаалах хувцас, хэрэгсэлтэй, хэрэглүүлж хэвшсэн 4. Ионжуулагч цацрагаас буюу рентген туяанаас хамгаалах заавар, зөвлөгөөг ажилтнуудад өгч, баталгаажуулсан 5. Рентген төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны болон ажиллуулах заавартай, мөрддөг 6. Рентген туяаны санамж, анхааруулга тэмдгийг ажлын байранд ил, харагдахуйц байршуулсан	
5.	Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, засвар, үйлчилгээг хийдэг байна.	5.1.Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг төлөвлөгөө, графикийн дагуу хийдэг байх	1. Засвар үйлчилгээний баталсан төлөвлөгөөтэй, хэрэгжүүлдэг 2. Засвар үйлчилгээ хийхэд ашигласан сэлбэг, дагалдах хэрэгслийн бүртгэл хөтөлдөг 3. Засвар үйлчилгээний тайлантай 4. Засвар үйлчилгээний гарын авлага ашигладаг	5, 4, 3, 2, 0
		5.2.Багаж,тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтыг тогтмол хөтөлдөг байх	1. Тоног төхөөрөмж бүрт техник ашиглалтын паспорттай 2. Техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтыг тогтмол, үнэн зөв хөтөлдөг 3. Ханган нийлүүлэгч байгууллагын суурилуулалт, засвар үйлчилгээний актыг хавсаргасан	5, 4, 3, 2, 0
		5.3.Тоног төхөөрөмжүүдэд техникийн үзлэг, үйлчилгээг тогтмол хийдэг байх	1. Тоног төхөөрөмжүүдэд техникийн үзлэг, үйлчилгээ хийх хуваарийг баталсан 2. Хуваарийн дагуу үзлэг, үйлчилгээг хийсэн 3. Үзлэг, үйлчилгээ хийсэн тухай тэмдэглэлийг техник ашиглалтын паспортад хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
		5.4.Тоног төхөөрөмжид тухай бүр засвар, үйлчилгээг хийдэг байх	1. Өндөр өртөгтэй, нарийн ажиллагаатай тоног төхөөрөмжид гадны байгууллагаар засвар үйлчилгээ хийлгэх гэрээтэй, баталгаажуулсан 2. Гэрээний хэрэгжилт акт, техник ашиглалтын паспорт хөтөлдөг 3. Тоног төхөөрөмжийн ажиллагаа, засвар үйлчилгээний тайлантай, холбогдох байгууллагад хүргүүлдэг 4. Шаардлагатай тоног төхөөрөмжид шалгалт, тохируулгыг хийлгэдэг	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

Дэд бүлэг 6. БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Барилга, байгууламжийн орчны шаардлага болон инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хангаж ажилладаг байна.	1.1. Төв нь барилга, инженерийн байгууламжийн байршил, бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан схем, зураглалтай байх	1. Барилга, инженерийн байгууламжийн байршил, бүрэлдэхүүн хэсэг /цахилгаан, сантехник, агааржуулагч, холбоо/ бүрийг харуулсан схем, зураглалтай, баталгаажуулсан 2. Барилга, инженерийн байгууламжийн үйл ажиллагаанд хийсэн үзлэг, шалгалт хийсэн тэмдэглэл, авсан арга хэмжээг баримтжуулсан	5, 4, 3, 2, 0
		1.2. Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянан шалгаж, сайжруулдаг тогтолцоо бүрдсэн байх	1. Байгууллага нь барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянан шалгаж, арга хэмжээ авах батлагдсан төлөвлөгөөтэй 2. Төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьдаг 3. Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаанд үзлэг, шалгалтыг тогтмол хийдэг 4. Үзлэг, шалгалт хийх хуудсыг боловсруулж ашигладаг 5. Үзлэг, шалгалтын дүгнэлт, авсан арга хэмжээний талаар тэмдэглэл хөтөлж, баримтжуулсан	5, 4, 3, 2, 0
		1.3. Байгууллагын хэвийн Үйл ажиллагааг хангах зорилгоор гадны байгууллагаар гүйцэтгүүлэх инженерийн үйлчилгээг хийж гүйцэтгүүлдэг гэрээтэй байх	1. Ус, цахилгаан, дулаан хангамж, агааржуулалтын систем, сантехник зэрэг инженерийн үйлчилгээ, засварыг гүйцэтгүүлэх гэрээг холбогдох байгууллага тус бүртэй байгуулсан, баталгаажуулсан 2. Гэрээнд заасан дагуу үзлэгийг хийж, бүртгэл, тэмдэглэл хөтөлдөг 3. Гэрээний гүйцэтгэлийг жил бүр хянадаг	5, 4, 3, 2, 0
		1.4. Байгууллагын гадаад орчин, барилга байгууламж нь эрүүл ахуйн шаардлага хангасан байх	1. Орчноос тусгаарласан хашаатай, хаягжуулсан 2. Байгууллагын хашаанд үйлчлүүлэгчид тав тухтай байдлыг хангах ногоон байгууламжтай, зүлэгжүүлсэн, зам талбайг цардаж тохижуулсан, сүүдрэвч, сандалтай 3. Гадна орчныг бүхэлд нь гэрэлтүүлэх гэрэлтүүлэгтэй 4. Тэргэнцэртэй үйлчлүүлэгчид зориулсан бариул бүхий налуу замтай 5. Машины зогсоолтой	5, 4, 3, 2, 0

2.	Эмнэлгийн усан хангамж болон цахилгааны нөөцийг бүрдүүлж, хэвийн ажиллагааг хангана.	2.1.Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгэвэртэй байх	<ol style="list-style-type: none"> 1. Цахилгааны нөөц үүсгэвэртэй, ажиллагааг тогтмол хянадаг 2. Цахилгааны нөөц үүсгэвэр нь байгууллагын хэмжээнд тусламж, үйлчилгээг хэвийн явуулах хүчин чадалтай 3. Сэлгэн залгалтын хэвийн ажиллагааг сар тутамд зохих мэргэжлийн байгууллагатай хамтарч хянадаг, баримтжуулсан 	5,4, 3, 2, 0
	2.2.Цахилгааны нөөц тэжээлийн найдваржилт хангагдсан байх	<ol style="list-style-type: none"> 1. АВР /Автомат сэлгэн залгагч/-ийн ажиллах техник болон схем зурагтай 2. Нөөц тэжээлийн хүчин чадал нь тухайн байгууллагын тоног төхөөрөмжүүдийн суурилагдсан хүчин чадлаас багагүй 3. Нөөц тэжээлийн сэлгэн залгалтын шуурхай ажиллагаа, найдваржилтыг хангаж буйг мэргэжлийн байгууллага зохих туршилтаар баталгаажуулсан 	5, 4, 3, 2, 0	
	2.3.Цахилгаан энергийн чанарын шаардлагад нийцсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Стандартад нийцсэн эсэхийг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хэмжилт, туршилт хийлгэж цахилгаан тэжээлийн чанарыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авсан 2. Хэмжилт хийх цэгүүдийг цахилгаан энергийн чанар доголдож болзошгүй /мэдрэмтгий/ хэрэглэгчид хийлгэх /ЭКГ, ЭХО, сэргээн засах эмчилгээний аппарат/ 3. Цахилгаан энергийн чанарыг доголдуулж болзошгүй /шугаман бус/ хэрэглэгчийн (сэргээн засах эмчилгээний аппарат) 4. Бүлэг хэрэглэгчид, оролт дээр хэмжилт туршилт хийдэг 	5,4, 3, 2, 0	
	2.4.Мэдээллийн аюулгүй байдлыг хангах орчин бүрдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Автомат сэлгэн залгагчаар (АВР) нөөц тэжээлд сэлгэн залгагдах боломжоор хангагдах (хүчин чадал нь тохирсон UPS-ээр дамжуулж тэжээх) 2. Статик цэнэгээс хамгаалагдсан (Сервирын өрөө потенциал жигдрүүлэгчтэй, газардуулгатай, резинэн шал тусгаарлагчтай, агаар чийгшүүлэгчтэй) 	5, 4, 3, 2, 0	
	2.5.Байгууллагын усан хангамжийн үйлчилгээ тасралтгүй байх	<ol style="list-style-type: none"> 1. 24 цагийн усан хангамжтай 2. Усны тасалдал гарсан тохиолдолд зохицуулах арга хэмжээг төлөвлөсөн 	5,4, 3, 2, 0	

			3. Ундны усны шинжилгээтэй, шаардлага хангасан	
3.	Даралтат сав болон агааржуулалтын системийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хангана.	3.1. Даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч тэмдэглэл хөтөлдөг, хяналт авдаг 2. Даралтат савыг баталгаажуулсан 3. Даралтат савыг хаягжуулж, бэхэлгээ хийсэн 4. Даралтат сав /баллон/-ыг зөөвөрлөх бэхэлгээтэй тэргэнцэр эсвэл тусгай зориулалтын тээвэрлэх хэрэгсэлтэй 5. Даралтат савыг ажиллуулах бичмэл заавартай 6. Даралтат савын ажиллуулсан үед тэмдэглэгээ хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0
		3.2. Агааржуулалтын хэвийн үйл ажиллагааг хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Агааржуулалтын хоолойн агаарт (халдваргүйжүүлэлт) бактериологийн шинжилгээ хийлгэсэн 2. Агааржуулалтын фильтр (шүүлтүүр)-ыг зохих шаардлагын дагуу сольж, үйлчилгээ хийлгэсэн 3. Агааржуулагчийн фильтр солих, халдваргүйжүүлэх, урсгал засварын ажлыг орчин үеийн шаардлагын түвшинд хийсэн 	5,4, 3, 2, 0
4.	Галын аюулгүй байдлыг хангаж ажиллана.	4.1. Галын аюулгүй байдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтад хамруулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын хэмжээнд мөрддөг галын аюулгүй ажиллагааны батлагдсан заавартай, мөрддөг 2. Харьяалах нутаг дэвсгэрийн Онцгой байдлын газар/хэлтэстэй хамтран ажилтнуудад жилд 1-2 удаа галын аюулгүй байдлын дадлага сургалтыг зохион байгуулж, баримтжуулсан 3. Галын аюулаас урьдчилан сэргийлэх буланг шаардлагатай цэгүүдэд байршуулсан 4. Гал унтраах хэрэгслийг ашиглах зааврыг өгдөг 	5, 4, 3, 2, 0
		4.2. Гал гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах тусгай тэмдэг бүхий гарц, схем зураглалтай байх	<ol style="list-style-type: none"> 1. Аврах гарцын схем, тэмдэг тэмдэглэгээнүүдийг шаардлагатай цэгүүдэд байршуулсан 2. Гал унтраах бүлгэмтэй 3. Гал унтраах хэрэгслээр хангасан, шаардлагатай цэгүүдэд байршуулсан 	5,4, 3, 2, 0
		4.3. Галын аюулын үед сэрэмжлүүлэх дуудлагын болон дохиоллын хэрэгслээр хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Галын аюулгүй байдлын үед ашиглах дуут дохио, холбоо хэрэгслээр хангасан 2. Аваарын гэрэлтүүлэгтэй 	5, 4, 3, 2, 0
		4.4. Галын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Харьяа аймаг, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтсээс жил бүр дүгнэлт гаргуулсан 	5,4, 3, 2, 0

	4.5. Галын хорыг шаардлагатай өрөө, нэгжид зохих журмын дагуу байрлуулж, хорыг цэнэглэсэн ба ашигласан бүртгэлийг хөтөлдөг байх	1. Галын хорын тоог гаргаж, бүртгэлжүүлсэн 2. Шаардлагатай цэгүүдэд галын хорыг байршуулсан 3. Галын хорыг цэнэглэсэн ба ашигласан бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн 4. Техник ашиглалтын паспорт хөтөлсөн тэмдэглэлтэй 5. Галын хорыг худалдан авсан, мэргэжлийн байгууллагаар цэнэглүүлсэн баримттай	5,4, 3, 2, 0
Онооны дүн	Авбал зохих оноо	...	
	Авсан оноо	...	

БҮЛЭГ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

I.НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.	Нийгмийн эрүүл мэнд /НЭМ/-ийн талаар баримтлах бодлого, чиглэл, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	1.1.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг хангасан байх	1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, стратеги бүрийн хүрээнд өөрийн байгууллагад хамаарах зорилго, зорилт, үйл ажиллагааг тусгасан төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлдэг 2. Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлан, дүгнэлттэй ажилладаг 3. Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч хамтран ажилладаг, тайлантай 4. Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг дүгнэдэг, үзүүлэлтүүдийн тоо, хувь нь жил бүр нэмэгдсэн	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ

	1.2.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг жил бүр төлөвлөн үр дүнг тооцдог байх	1. НЭМ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зардлыг төсөвлөсөн, үр дүнг тооцдог 2. НЭМ-ийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн санхүүжилтийг баталсан, үр дүнг тооцдог	5, 4, 3, 2, 0
	1.3.НЭМ-ийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж ажилладаг байх	1. Хэрэгжүүлж байгаа НЭМ-ийн үндэсний хөтөлбөр, стратегийн хэрэгжилтэд явцын үнэлгээ хийж, дүгнэлт өгдөг 2. Тайлантай, гарсан үр дүнг тооцсон	5, 4, 3, 2, 0
	1.4.Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж, үр дүнг тооцсон байх	1. Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн тархалтын хандлагыг тодорхойлж, тандалт судалгаа хийдэг 2. Судалгааны тайлантай 3. Авсан арга хэмжээний үр дүнг тооцдог	5, 4, 3, 2, 0
	1.5.Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулдаг байх	1. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааг хийдэг 2. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний бүртгэл, судалгаатай 3. Халдварт бус өвчний эрсдэлт бүлгийн судалгааг гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг	5, 4, 3, 2, 0
	1.6.Халдварт өвчин гарахад нөлөөлөх хүчин зүйлийг судалж, эрсдлээс сэргийлэх чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажилладаг байх	1. Халдварт өвчин гарахад нөлөөлөх хүрээлэн буй орчны эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, эрсдлээс сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тодорхой ажлууд хийсэн, тайлантай 2. Халдварт өвчнөөс сэргийлж заавал заавал хийх, нөхөн, нэмэлт, тархвар судлалын заалтаар болон сайн дурын дархлаажуулалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон	5, 4, 3, 2, 0
	1.7.Халдварт өвчний урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа хийдэг байх	1. Хүн амыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулдаг 2. Халдварт өвчинд өртөх эрсдэлт бүлгийн судалгааг гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг	5, 4, 3, 2, 0

			<ul style="list-style-type: none"> 3. Халдварт өвчний тохиолдол аймаг, улсын дундажаас доогуур, буурсан 4. Цочмог халдварт өвчин гарсан тохиолдолд голомтын арга хэмжээг шуурхай авч, тархалтаас сэргийлсэн 5. Тандалт судалгааны тайлан, дүгнэлттэй 6. Сүрьеэ, БЗДХ-ийн урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд иргэдийг хамруулж, бүртгэлтэй ажилладаг 	
		1.8.Шинэ болон шинээр сэргэн тархаж байгаа халдвар, томуу, томуу тест өвчин, зоонозын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байх	<ul style="list-style-type: none"> 1. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвар, томуу, томуу тест өвчин, зоонозын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа хийдэг 2. Дээрх чиглэл бүрээр хийсэн ажлын тайлантай 	5, 4, 3, 2, 0
2.	Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	2.1.Хүн амын бүртгэл, мэдээллийг шинэчлэн хөтөлж, баяжилт хийдэг байх	<ul style="list-style-type: none"> 1. Өөрийн харъяаллын хүн амын бүртгэл, мэдээллийг жил бүр шинэчлэн хөтөлж, баяжилт хийдэг 2. Мэдээллийг тусламж, үйлчилгээний төлөвлөлт, зохион байгуулалтанд ашигладаг 3. Бүртгэл, мэдээлэлтэй холбоотой анхан шатны бүртгэлийн маягтуудыг хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0
2.2.Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлэгт үнэлгээ, дүгнэлт хийж, хяналт тогтоох, цаашид авах арга хэмжээг төлөвлөдөг байх		<ul style="list-style-type: none"> 1. Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлэгт жил бүр үнэлгээ, дүгнэлт хийдэг 2. Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийг үндэслэн хяналт тогтоох, цаашид авах арга хэмжээг төлөвлөдөг 3. Авсан арга хэмжээний үр дүнг тооцдог 4. Иргэний эрүүл мэндийн бүлэг, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийн бүлгийн үнэлгээ хийсэн бүртгэл, анхан шатны бүртгэлийн маягыг хөтөлдөг 5. Тайлантай 	5, 4, 3, 2, 0	
2.3.Өөрийн харъяаллын хүн амын өвчлөлийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлдог байх		<ul style="list-style-type: none"> 1. Жил бүр зонхилон тохиолдох өвчин эмгэгийн тархалтын хандлагыг тодорхойлж, тандалт судалгаа хийсэн 2. Судалгааны дүгнэлтэд үндэслэн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн 3. Судалгааны тайлантай 4. Авсан арга хэмжээний үр дүнг тооцдог 	5, 4, 3, 2, 0	

		2.4.Иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх халдварт өвчний хүчин зүйлийн тандалтыг хийдэг байх	1. Халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж, үр дүнг тооцдог 2. Халдварт өвчнийг бууруулах арга хэмжээ авдаг 3. Халдварт өвчин буурсан үзүүлэлттэй	5, 4, 3, 2, 0
		2.5.Халдварт бус өвчин үүсэхэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн судалгаа хийдэг байх	1. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх тандалт судалгаа хийдэг 2. Судалгааны тайлан дүгнэлттэй, үр дүнг тооцсон 3. Халдварт бус өвчнийг бууруулах арга хэмжээ авсан тайлантай 1. Халдварт бус өвчин буурсан үзүүлэлттэй	5, 4, 3, 2, 0
3.	Дархлаажуулалтыг товллын дагуу зохион байгуулсан байна.	3.1.Дархлаажуулалт хийх нөхцөл, шаардлагыг хангасан байх	1. Орон тоогоор болон орон ажиллах сувилагчийг сургаж, бэлтгэсэн 2. Дархлаажуулалт хийх эрүүл ахуйн шаардлага хангасан өрөөтэй 3. Вакцин хадгалах зориулалтын хөргөгч /тог баригчтай/, хэм хяналтын хэрэгслүүдтэй	5, 4, 3, 2, 0
		3.2.Хамрагдвал зохих хүүхдийг товлот дархлаажуулалтанд бүрэн хамруулсан байх	1. Дархлаажуулалтыг товллын дагуу хийдэг /тавт вакцин, улаан бурхан, гахайн хавдар, улаанууд, улаануудын эсрэг вакцины хамралт/ 2. Хүрч үйлчлэхэд бэрхшээлтэй өрхийн хүүхдийг дархлаажуулалтанд хамруулсан, бүртгэлтэй 3. Нөхөн дархлаажуулалтад хамруулсан бүртгэл, судалгаатай 4. Дархлаажуулалтыг зохион байгуулсан тайлан, дүгнэлттэй 5. Дархлаажуулалтын үзүүлэлтийг улс, аймаг, нийслэлийн дундаж үзүүлэлт болон “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тоо, хэмжээ, чанарын үзүүлэлт”-тэй харьцуулсан дүгнэлттэй	5, 4, 3, 2, 0
4.	Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг байна.	4.1.Хувь хүн, байгууллага, хамт олон, үйлчлүүлэгчид чиглэсэн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулдаг байх	1. Эрүүл иргэн, өрх гэр, эрүүл ажлын байр, эрүүл хамт олон, эрүүл орчин бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулан, үр дүнг тооцон ажилласан байх 2. Албан байгууллага, аж ахуйн нэгжийг эрүүл мэндийг дэмжигч байгууллага болоход мэргэжлийн арга	5, 4, 3, 2, 0

			<p>зүйгээр хангадаг</p> <p>3. Архи, тамхигүй орчин бүрдүүлэх, архины зохисгүй хэрэглээг сурталчилдаг</p> <p>4. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэх, үр дүнг тооцон, ахиц гарсан</p>	
		4.2.Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж ажилладаг байх	<p>1. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр орон нутгийн удирдлага, албан байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний дэмжлэгийг авдаг</p> <p>2. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд иргэд, байгууллага, эрүүл мэндийн сайн дурын идэвхтнүүдийг оролцуулдаг</p> <p>3. Эрүүл мэндийн сайн дурын идэвхтнийг эрүүл мэндийг дэмжих чиглэлээр жил бүр бэлтгэдэг, давтан сургаж, хамтран ажилладаг</p>	5, 4, 3, 2, 0
		4.3.Хувь хүний чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажилладаг байх	<p>1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хувь хүний чадварыг хөгжүүлэх арга, дадлыг сургах арга хэмжээ авдаг</p> <p>2. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчийн асран хамгаалагчдад дадал эзэмшүүлэх ажлыг зохион байгуулсан</p>	5, 4, 3, 2, 0
		4.4.Хүн амын дунд дасгал хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийг хийдэг байх	<p>1. Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх өрөөг стандартын дагуу зохион байгуулж, тоног төхөөрөмжөөр хангасан</p> <p>2. Дасгал хөдөлгөөний жортой, дасгал хөдөлгөөнийг зааж сургадаг</p>	5, 4, 3, 2, 0
		4.5.Сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж, хүүхдийн өсөлт, хөгжлийг үнэлэх, биеийн индексийг тодорхойлох болон амны хөндий гүйлсэн булчирхай, харааны эмгэгийг ирүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулдаг байх	<p>1. Сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж, хамтран ажилладаг</p> <p>2. Хүүхдийн өсөлт, хөгжлийг үнэлэх, биеийн индексийг тодорхойлж, дүгнэлт өгч, холбогдох арга хэмжээ авсан</p> <p>3. Хүүхдийн харааны эмгэгийг ирүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй хамтран хийсэн, үр дүн гарсан</p> <p>4. Хүүхдийн харааны эмгэгийг ирүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийн мэдээ, тайлантай</p>	5, 4, 3, 2, 0
5.	Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх эрүүл мэндийн мэдээлэл, сургалт	5.1.Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны хөтөлбөр /төлөвлөгөө/-тэй,	<p>1. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааны батлагдсан төлөвлөгөөтэй</p> <p>2. Төлөвлөгөөний дагуу мэдээлэл, сургалт,</p>	5, 4, 3, 2, 0

сурталчилгааг календарчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг байна.	хэрэгжүүлдэг байх	сурталчилгааг явуулдаг, тайлантай 3. Сургалтын үр дүнгийн судалгаатай 1. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал, гарын авлагатай, тогтмол баяжуулж, ашигладаг	
	5.2.Зонхилон тохиолдох өвчин эмгэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа /МСС/-г тогтмол хийдэг байх	1. Зонхилон тохиолдох өвчин эмгэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр МСС хийдэг 2. МСС-ны төрөл, хэвлүүлсэн МСС-ны материалын төрөл, тоо 3. МСС хийсэн бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
	5.3.Үйлчлүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөлөөр хангасан байх	1. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт явуулах өрөөтэй, шаардлагатай хэрэгслээр хангасан 2. Ганцаарчилсан зөвлөгөө авах нөхцөлийг хангасан 3. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудыг сургадаг 4. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх видео, үзүүлэн, гарын авлага, материалаар хангасан 5. Тухайн жилд шинээр бэлтгэсэн МСС-ны материалын тоо, төрөл 6. Тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан чиглэлээр зорилтод бүлэгт зөвлөгөө өгдөг, тайлантай	5, 4, 3, 2, 0
	5.4.Амбулаторийн хүлээлгийн танхимуудад МСС-г тасралтгүй явуулдаг байх	1. Хүлээлгийн танхимуудад МСС явуулах хэрэгсэлтэй, МСС-г тогтмол явуулдаг 2. Хариуцсан ажилтантай 3. Үйлчлүүлэгчийг гарын авлага, материалаар хангасан	5, 4, 3, 2, 0
	5.5.Иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулсан байх	1. Халдварт бус өвчнөөс сэргийлэх /архи, тамхи, мансууруулах бодисыг хэрэглэх буруу зан үйлийг өөрчлөх, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн хийх/ эрүүл зан үйл төлөвшүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн, тайлантай 2. Халдварт өвчнөөс сэргийлэх /БЗДХ, ХДХВ, сүрьеэ болон бусад чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн 3. Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олгох, жирэмслэлтээс сэргийлэх аргад сургах чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн, тайлантай 4. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион	5, 4, 3, 2, 0

			байгуулсан ажил, үр дүн, тайлантай 5. Эрүүл, зөв зохистой хооллолтыг дэмжих чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн, тайлантай	
		5.6. Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг хийдэг байх	1. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах талаар сургалт, сурталчилгаа хийдэг 2. Үе тэнгийн сургагч багш, сайн дурын идэвхтэнийг бэлтгэсэн 3. Үе тэнгийн сургагч багш, сайн дурын идэвхтэний тоо жил бүр нэмэгдэж, үйл ажиллагаа тогтмолжсон	5, 4, 3, 2, 0
6.	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулж үр дүн гарсан байна.	6.1. Урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	1. Харъяалах нутаг дэвсгэрийн хүн амыг насны ангиллаар жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг 2. Үзлэгээр өвчин эмгэг илэрсэн тохиолдолд холбогдох удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу дээд шатны байгууллагад шилжүүлэх, оношлох, эмчлэх, хянах, эргэн мэдээлж ажилладаг 3. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй 4. Урьдчилан сэргийлэх үзлэгийг хувь жил бүр нэмэгдсэн 5. Хүн амын эрүүл мэндийн нэг, хоёрдугаар бүлгийн иргэдийн 80%-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан 6. Хүн амыг тэмбүү, сүрьеэ өвчний илрүүлэг үзлэгт хамруулсан хувь 7. Эмчлэн эрүүлжүүлсэн, хяналтад авсан үйлчлүүлэгчийн тоо, хувь	5, 4, 3, 2, 0
		6.2. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлдэг байх	1. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг 2. Шүд цоорох болон бусад өвчин эмгэгтэй илэрсэн хүүхдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг хамтран хийдэг 3. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан хүүхдийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй 4. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь жил бүр нэмэгдсэн 5. Эмчлэн эрүүлжүүлсэн, хяналтад авсан үйлчлүүлэгчийн тоо, хувь	5, 4, 3, 2, 0

		<p>6.3. Артерийн даралт ихсэлтийн эрт илрүүлэг үзлэгийг хийж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тухайн жилд хамрагвал зохих зорилтот бүлгийн иргэдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувь 2. Эмчилгээнд хамруулсан хүний тоо/ хувь 3. Зохистой түвшинд хянагдаж байгаа хүний тоо/ хувь 4. Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилж, хянадаг 5. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 6. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй 7. Артерийн даралт ихсэлт өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн 	<p>5, 4, 3, 2, 0</p>
		<p>6.4. Чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгийг хийж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тухайн жилд хамрагдвал зохих зорилтот бүлгийн иргэдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувь 2. Эмчилгээнд хамруулсан хүний тоо/ хувь 3. Зохистой түвшинд хянагдаж байгаа хүний тоо/ хувь 4. Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилж, хянадаг 5. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 6. Чихрийн шижин өвчний илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй 	<p>5, 4, 3, 2, 0</p>
		<p>6.5. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тухайн жилд хамрагдвал зохих зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувь 2. Эмчилгээнд хамруулсан хүний тоо/ хувь 3. Зохистой түвшинд хянагдаж байгаа эмэгтэйчүүдийн тоо/ хувь 4. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 5. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн 6. Хавдрын эрт шатанд оношилсон, эмчилсэн хувь нэмэгдсэн 	<p>5, 4, 3, 2, 0</p>

		7. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй	
	6.4.Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Тухайн жилд хамрагдвал зохих эмэгтэйчүүдийг үзлэгт хамруулсан тоо/хувь, үүнээс шинээр илэрсэн тохиолдлын тоо/хувь 2. Эмчилгээнд хамруулсан эмэгтэйчүүдийн тоо/ хувь 3. Зохистой түвшинд хянагдаж байгаа эмэгтэйчүүдийн тоо/ хувь 4. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 5. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн 6. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэл /анхан шатны бүртгэлийн маягт/-тэй 	5, 4, 3, 2, 0
	6.5.Элэг, улаан хоолой, ходоод, бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэгүзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлж, хянадаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Элэг, улаан хоолой, ходоод, бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг тус бүрд тухайн жилд хамруулсан зорилтот бүлгийн иргэдийн тоо /хувь 2. Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилгээ, хяналтыг явуулдаг 3. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлэх, хянах, эргэн мэдээлдэг 4. Элэг, улаан хоолой, ходоод, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хувь нэмэгдсэн 5. Хавдрын эрт шатанд оношилсон, эмчилсэн хувь нэмэгдсэн 6. Үзлэгийн бүртгэл, шилжүүлсэн, хянасан үйлчлүүлэгчийн бүртгэлтэй /анхан шатны бүртгэлийн маягт/ 	5, 4, 3, 2, 0
	6.6.Зүрхний архаг дутагдлын болон дислипидемийн эрт илрүүлэг хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Зүрхний архаг дутагдлын эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо/ хувь 2. Дислипидемийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо/ хувь 3. Холбогдох эмнэлзүйн зааврын дагуу эмчилж, хянасан 4. Шаардлагатай үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалын байгууллагад шилжүүлж, хянаж, эргэн мэдээлдэг 5. Үзлэгийн бүртгэл, эмчилсэн, шилжүүлсэн, хянасан 	5, 4, 3, 2, 0

			үйлчлүүлэгчийн бүртгэлтэй /анхан шатны бүртгэлийн маягт/	
		6.7.Эрт илрүүлэг үзлэгийн хувь, үзүүлэлт өмнөх жилээс нэмэгдсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Умайн хүзүү, хөх, элэгний хорт хавдрын, артерийн даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгийн хувь өмнөх жилээс нэмэгдсэн 2. Хорт хавдрыг эрт үед оношилсон хувь нэмэгдсэн 3. Илрүүлэг үзлэг тус бүрийн хувь аймаг, нийслэл, дүүргийн дундаж үзүүлэлтээс өндөр байх 	5, 4, 3, 2, 0
7.	Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээг үзүүлдэг байна.	7.1.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэлтэй, жил бүр баяжилт хийж, үзлэг зохион байгуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэлтэй, жил бүр баяжилт хийдэг 2. Эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан, бүртгэл, судалгаатай 3. Хяналтанд авч, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авдаг 	5, 4, 3, 2, 0
		7.2.Эмэгтэйчүүдийг хөхөө шалгах аргад сургасан байх, бүртгэлтэй байх	<ol style="list-style-type: none"> 1. Хөхөө шалгах аргад сургасан эмэгтэйчүүдийн бүртгэлтэй 2. Сургалтын үзүүлэн, гарын авлагатай 	5, 4, 3, 2, 0
		7.3.Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олгох, жирэмслэхээс сэргийлэх аргад сургах ажлыг зохион байгуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа хийдэг 2. Жирэмслэхээс сэргийлэх аргад сургадаг 3. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгаатай 4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээний хувь 5. Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн нөөцтэй 	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

II. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ				
1.	Эх, нярайд үзүүлэх тусламж,	1.1.Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэх	1. Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг/	Шалгуур үзүүлэлт

үйлчилгээний зохион байгуулалтыг хийсэн байна.	тасаг/ нэгжийг стандарт шаардлагын дагуу зохион байгуулсан байх	нэгжийг зохион байгуулсан 2. Төрөх, нярайн тасаг, хагалгааны хэсэг, болон бусад нэгж, өрөөний байршил, урсгал зохион байгуулалт эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуйн шаардлага стандартыг хангасан 3. Агааржуулалт, гэрэлтүүлэг, дулаан нь стандарт шаардлагыг хангасан 4. Өрөө, тасалгааны хаалга, хаалганы босго нь ортой болон тэргэнцэртэй үйлчлүүлэгчийг зөөвөрлөхөд саадгүй байх	бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
	1.2.Эх, нярайг хүлээн авах, шилжүүлэх, эмнэлгээс гаргах, эргэн хянах журмыг мөрддөг байх	1. Үйлчлүүлэгчийг хүлээн авах, шилжүүлэх, эмнэлгээс гаргах, эргэн хянах журамтай, мөрддөг 2. Хүлээн авсан, шилжүүлсэн, эмнэлгээс гаргасан, эргэн хянасан бүртгэл хөтөлдөг 3. Анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
	1.3.Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр батлагдсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байх	1. Эх, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний бодлого, үндэсний хөтөлбөрийн холбогдох зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан 2. Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэдэг, тайлантай 3. Батлагдсан журам, дүрмийн хэрэгжилт, тайлан, дүгнэлт, үр дүнг дүгнэдэг	5, 4, 3, 2, 0
	1.4.Байгууллагын онцлогт тохируулан эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхамыг бодлогын баримт бичигтээ тусган хэрэгжүүлдэг байх	1. Өөрийн байгууллагын баталсан баримт бичигт эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-аас хамгийн багадаа “8 алхам”-ыг тусгасан 2. Ажлын байранд ашиглаж байгаа удирдамж, заавартай 3. Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлантай 4. Ажилтны ажлын гүйцэтгэлд хийсэн үнэлгээ, хэрэгжилтийн хувь	5, 4, 3, 2, 0
	1.5.Нярайн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт) зэргийг худалдаалах, ханган нийлүүлэх болон үнийн хямдрал, хөнгөлөлт тусгай урамшуулал өгөхийг хориглосон байх	1. “Нялх,балчир хүүхдийн хүнсний тухай хууль”-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлдэг 2. Байгууллага дотор нярайн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт) зэргийг худалдаалдаггүй 3. Авсан арга хэмжээ, үр дүн, гүйцэтгэлтэй	5, 4, 3, 2, 0

		1.6.Нярайн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт)-ийн үйлдвэрлэгчийн лого, зураг, дүрс зар сурталчилгааг байрлуулахгүй байх	1. Эрүүл мэндийн байгууллага дотор нярайн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт)-ийн үйлдвэрлэгчийн лого, зураг, дүрс зар сурталчилгааг байрлуулаагүй	5, 4, 3, 2, 0
		1.7.Эх барих, нярайн эмч, эх баригч, сувилагч нарыг нярайн эрт үеийн болон эх барихын нэн шаардлагатай тусламжийн сургалтад хамруулсан, тусламжийг “баг”-аар үзүүлдэг байх	1. Сургалтын хөтөлбөр, сургалтанд хамруулсан бүртгэл, гэрчилгээ, бусад баримттай 2. Багаар ажиллуулах даргын тушаалтай	5, 4, 3, 2, 0
		1.8.Нийт ажилтнууд нярай хүүхдийг эхийн сүүгээр хооллох чиглэлээр сургалтанд хамрагдсан байх	1. Сургалтын тайлан (Сургалтад хамрагдсан ажилтны бүртгэл, гэрчилгээ, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр г.м)-тай 2. Сүүлийн 2 жилд сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо/хувь	5, 4, 3, 2, 0
		1.9.Эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн эрхзүйн баримт бичгийг эрүүл мэндийн ажилтнуудад танилцуулах сургалт хийсэн, ажилтнууд мэддэг байх	1. Танилцуулах сургалтын төлөвлөгөө, хамрагдсан ажилтнуудын бүртгэлтэй, сургалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтны тоо/хувь, 2. Сургалтын тайлантай	5, 4, 3, 2, 0
		1.10.Ажлаа хийж байгаа эхчүүд хүүхдээ хөхүүлэх орчин бүрдүүлж, дэмжлэг үзүүлж ажилладаг байх	1. Ажилчдад зориулсан хүүхэд хөхүүлэх өрөөтэй, тав тухтай, тохижуулсан 2. Ажлын цаг, ачааллыг зохицуулсан	5, 4, 3, 2, 0
2.	Жирэмсний хяналтыг сайжруулж, хүндрэлээс сэргийлэх арга хэмжээ авдаг байна.	2.1.Жирэмсний эхний 3 сарын дотор хяналтад хамрагдсан хувь нэмэгдсэн байх	1. Жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 93% ба түүнээс дээш 2. Аймаг, нийслэл, улсын дундаж үзүүлэлттэй харьцуулан үнэлж дүгнэдэг, сайжруулах арга хэмжээ авсан	5, 4, 3, 2, 0
		2.2.Жирэмсний хяналтыг удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг байх	1. Эмч, сувилагч нар нь сургагдсан /эх баригч/ 2. Жирэмсний хяналтыг холбогдох журам, удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг 3. Жирэмсэн эхийг 100% хяналтанд авсан 4. Шилжих хөдөлгөөн хийгдсэн жирэмсэн эхчүүдийн	

			бүртгэлтэй 1. Эхчүүдэд жирэмсний хяналтын талаар зөвлөгөө өгдөг	
		2.3.Эрсдэлтэй жирэмснийг илрүүлж, хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх	1. Жирэмсний хяналтын үед эхэд зургаа ба түүнээс дээш удаа үзлэг хийж, хамралтын хувийг тооцсон 2. Холбогдох журамд заасан дагуу жирэмсэн эмэгтэйд эрсдэлийн үнэлгээ хийдэг 3. Эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйн бүртгэлтэй, эх барих, эмэгтэйчүүдийн эмчтэй хамтран хяналтыг хийж, жирэмслэлт, төрөлтийг шийдвэрлэдэг 4. Жирэмслэлт, төрөлтийг шийдвэрлэсэн байдал, үр дүн 5. Жирэмсэн болон хөхүүл эхийг олон найрлагатай бичил тэжээлээр хангадаг, бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
		2.4.Хүндрэлтэй төрсөн эх, нярайн судалгаатай байх, гэрийн эргэлт, хяналтыг тогтмол хийдэг байх	1. Хүндрэлтэй төрсөн эх, нярайн судалгаатай 2. Эх, нярайн гэрийн эргэлтийг амаржих газраас гарснаас хойш 3-7 хоногийн дотор хийсэн, цаашдын хяналт тогтмолжсон 3. Эх, нярайн гэрийн эргэлт хийсэн, эмчилгээ, зөвлөгөөг холбогдох баримт бичигт тэмдэглэдэг	5, 4, 3, 2, 0
		2.5.Жирэмсний хяналтын явцад ургийн гажиг илрүүлэх шинжилгээ хийлгэдэг байх	1. Жирэмсэн эмэгтэйг хяналтын явцад ургийн гажиг илрүүлэх шинжилгээнд хамруулдаг 2. Ургийн гажиг илрүүлсэн бүртгэлтэй 3. Авсан арга хэмжээ, дүгнэлттэй	5, 4, 3, 2, 0
		2.6.Жирэмсний хяналт, төрөх үеийн тусламжинд тэмбүү, ХДХВ, элэгний В,С вирусийн халдвар илрүүлэн, эмчилдэг байх	1. Жирэмсэн эмэтэйд тэмбүү, ХДХВ, элэгний В,С вирусийн халдварыг илрүүлэх хурдавчилсан сорил хийдэг 2. Өвчтэй илэрсэн жирэмсэн эмэгтэйд мэргэжлийн эмч нарын зөвлөгөө авч, эмчилгээ, хяналтыг хийдэг	5, 4, 3, 2, 0
3.	Төрлөг удирдах стандарт, удирдамж, зааврыг мөрддөг байна.	3.1.Эмч, эх баригчийг төрлөг удирдах стандарт, удирдамж, эмнэлзүйн заавраар хангасан байх	1. Мөрдөж буй стандарт удирдамж, эмнэлзүйн зааврын жагсаалттай 2. Сонгон мөрдөх стандарт, заавал мөрдөх стандартуудын эмхтгэлийг бэлтгэж ажилтнуудад таниулсан, гарын авлагаар хангасан 3. Төрлөгийг удирдамж, зааврын дагуу удирдаж, тэмдэглэл хөтөлдөг	5, 4, 3, 2, 0

		3.2.Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарын төрлөг удирдах ур чадварыг сайжруулах сургалт хийдэг байх	1. Сургалт хийх ур чадварын өрөө, сургалтын хөтөлбөр, биет үзүүлэн, сургалт хийсэн бүртгэлтэй 2. Сургалтын тайлан, дүгнэлт, үр дүн	5, 4, 3, 2, 0
4.	Имж асаргаа, ангир уураг, эхийн сүүгээр дагнан хооллох дадлуудыг хэвшүүлсэн байна.	4.1.Төрсний дараа эх, хүүхдийг арьс арьсаар нь шүргэлцүүлсэн, 1 цагийн дотор ангир уургаар амлуулсан байх байх	1. Имж асаргааг хийсэн тайлантай 2. 1 цагийн дотор эх, хүүхдийг арьс арьсаар шүргэлцүүлсэн, ангир уургаар амлуулсан нярайн тоо/хувь,	5, 4, 3, 2, 0
		4.2.Нярайг эмнэлэгт байх хугацаанд эхийн сүүгээр дагнан хооллосон байх	1. Үйл ажиллагааны тайлантай /Эхийн өөрийн сүү юу ? эсвэл Донор эхийн сүү юу?) 2. Бүртгэл, судалгаатай 3. Эхийн сүүгээр хооллолтын хувь нэмэгдсэн	5, 4, 3, 2, 0
		4.3.Хүндрэлтэй төрсөн нярайд 1-2 цагийн дотор ангир уургаар амлуулахад нь тусламж, дэмжлэг үзүүлсэн байх	1. Хүндрэлтэй төрсөн нярайд 1-2 цагийн дотор ангир уургаар амлуулсан 2. Зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн төрсөн эхийн тоо/хувь	5, 4, 3, 2, 0
5.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулж, аюулгүй байдлыг хангаж ажиллана.	5.1.Төрөх тасгийн байр, орчин халдварын эрсдэлгүй, аюулгүй байдлыг хангасан байх	1. Шаардлагатай үед төрөх өрөөг сэлгэж ажиллуулах нөхцөл бүрдүүлсэн 2. Төрөх өрөөнд жил бүр урсгал засвар хийдэг 3. Халдварын сэжигтэй эх, нярайг тусгаарлах өрөөг зохион байгуулсан 4. Төрөх, нярайн өрөөний дулаан 22-25 хэм 5. Нярайн кувейц хүрэлцээтэй 6. Нярайд хэрэглэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн халдваргүйжүүлэлтэд хор багатай бодис (фенол, альдегид агуулаагүй) ашигладаг	5, 4, 3, 2, 0
		5.2.Төрсөн эх, нярайг халдварт өртөхөөс сэргийлдэг байх	1. Халдварын сэжигтэй эх, нярайг тусгаарлах арга хэмжээг хэрэгжүүлдэг 2. Олон туншил (ампултай) бүхий тарилгын уусмалыг хувааж хэрэглэдэггүй 3. ЭМА-ы гарын ариун цэврийн сахилтанд үнэлгээ хийдэг 4. Төрөлт удирдахад эх барихын иж бүрдэл бүхий нэг удаагийн хэрэгслийг ашигладаг 5. Нярайн салиа соруулагч, амбуны хошуу зэргийг нэг	5, 4, 3, 2, 0

		удаагаар хэрэглэх, давтан хэрэглэх зориулалттай бол угааж, халдваргүйжүүлж хэрэглэдэг	
		6. Амьсгалын замын халдвар, томуу томуу төст өвчний шинж тэмдэг бүхий ажилтан байгаа бол төрөх, нярайн тасагт ажиллуулахгүй байх түр хугацаанд зохицуулалт хийдэг	
	5.3.Төрөлтийн явцад эхээс нярайд В, С вируст гепатитын халдвар дамжихаас сэргийлэх арга хэмжээ авдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. В, С, D вируст гепатитын архаг халдвартай эхийн мэдээллийг төрөлтийн түүхэнд тэмдэглэсэн 2. Төрөлтийн явцад нярайн арьсны бүрэн бүтэн байдал алдагдах эрсдлээс сэргийлдэг 3. Нярайд халдвар дамжих эрсдэлт хүчин зүйл гарсан бол ХСХ-ын ажилтанд мэдээлсэн 4. В гепатитын архаг халдвартай эхээс төрсөн нярайд В гепатитын эсрэг дархлаажуулалтад 12 цагийн дотор хамруулсан 5. В гепатитын вакцины 24 цагийн доторх хамралтын хувийг сар тутам тооцож гаргасан 	5, 4, 3, 2, 0
	5.4.Төрсний дараах эх, нярайн халдварын илрүүлэх тандалтыг хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Төрсөн эхэд халдварын шинж тэмдэг илрүүлэх тандалтыг эмнэлэгт байх хугацаанд хийдэг 2. Нярайд халдвар илрүүлэх тандалтыг эмнэлэгт байх хугацаанд хийдэг 3. Халдварын сэжигтэй эх, нярайгаас нян судлалын шинжилгээнд сорьц авч үүсгэгч илрүүлэх шинжилгээ хийдэг 4. Халдварын тохиолдол илэрвэл эх, нярайн халдварын түвшинг тооцсон 	5, 4, 3, 2, 0
	5.5.Төрөлт, үзлэг, хагалгааны явцад хувийн хамгаалах хувцас хэрэглэлийг зөв хэрэглэдэг байх /нүдний шил, шингэн нэвтэрдэггүй халад, битүү гутал, амны хаалт гэх мэт/	<ol style="list-style-type: none"> 1. Ажилтнуудыг шаардлага хангасан хамгаалах хэрэгслээр хангасан 2. Хамгаалах хэрэгслийг шаардлагын дагуу хэрэглэдэг 3. Ажилтнуудын хамгаалах хэрэгслийн хэрэглээг хяналтын хуудсаар үнэлдэг 	5, 4, 3, 2, 0
	5.6.Төрөлтийн явцад ариун материал хэрэглэдэг байх	1. Нэг удаагийн халад, малгай, ариун бээлий, хүйн хавчуур, нярайн ариун даавуу 2 ш, нярайн малгай, 1 удаагийн дэвсгэр, ариун багаж, эхийн дулаан хөнжлөөр хангасан	5, 4, 3, 2, 0

6.	Төрсний дараах тусламж, үйлчилгээ үзүүлдэг байна.	6.1. Төрсний дараах хяналтыг стандарт, удирдамж, зааврын дагуу үзүүлдэг байх	1. Төрсний дараа эх, нярайд тавих хяналтыг стандарт, удирдамж, зааврын дагуу хийдэг 2. Эх, нярайд тавьсан хяналтыг түүхэнд тэмдэглэдэг	5, 4, 3, 2, 0
		6.2.Эхчүүдэд дан хөхөөр хооллох талаар мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол явуулдаг байх	1. Сургалт, сурталчилгаанд хамрагдсан эхчүүдийн тоо 2. Сургалт, сурталчилгааны тайлантай	5, 4, 3, 2, 0
		6.3. Жирэмсэн болон төрсөн эх, нярайд тусламж, үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгдөг байх	1. Жирэмсэн эхийн хөхийг бэлтгэх, дасгал хөдөлгөөн заах, төрөхөд бэлтгэх зөвлөгөө өгдөг 2. Төрсний дараа эхэд хөхөө арчлах, зөв хөхүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг 3. Нярайн хүй цэвэрлэх, нүд, ам, хамрыг цэвэрлэх, усанд оруулах, иллэг хийхийг эхэд зааж сургадаг зөвлөгөө өгдөг	5, 4, 3, 2, 0
7.	Эхийн амрах байрыг зохион байгуулж, жирэмсний хүндрэлээс сэргийлэх арга хэмжээ авсан байна.	7.1 Ая тухтай нөхцөлийг хангасан эхчүүдийн амрах байртай, үйлчлэх хүрээний эхчүүдийг амраасан хувь жил бүр нэмэгдсэн байх	1. Эхийн амрах байр нь ая тухтай, тохижуулсан 2. Амрах байранд байгаа жирэмсэн эхэд хяналт тавих журамтай, мөрддөг 3. Эхийн амрах байранд хянах эхчүүдийн бүртгэлийг урьдчилан гаргаж, амраасан 4. Эхчүүдийг амраасан хувь жил бүр нэмэгдсэн, жирэмсний хүндрэл буурсан үзүүлэлттэй	5, 4, 3, 2, 0
2.Хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ				
1.	Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлж ажиллана.	1.1.Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх	1. Хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхэд сургагдсан эмч, сувилагчтай 2. Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлсэн 3. Үр дүнг тооцсон 4. Хүүхдийн өвчний цогц менежментийн удирамж, зааврыг мөрддөг 5. Бүртгэл, мэдээлэлтэй 6. Гардан үйлдлийг хянаж, үнэлгээ өгдөг	5, 4, 3, 2, 0
2.	Хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж, эмчлэн	2.1.Хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж насны бүлгээр хянах графиктай, мөрдөж ажилладаг байх	1. Хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан, үзлэг хийсэн тэмдэглэлтэй 2. Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлт, үр дүн 3. Насны бүлгээр хяналтыг хийх хуваарьтай, мөрддөг	5, 4, 3, 2, 0

	эрүүлжүүлж, насны бүлгээр хянах ажлыг зохион байгуулдаг байна.	2.2.Нэг хүртэлх насны хүүхдийг гэрийн идэвхтэй эргэлтээр үзэж тусламж, үйлчилгээ үзүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Гэрийн эргэлтийн хуваарийг баталсан 2. Гэрийн үзлэг хийсэн тэмдэглэлийг картанд хөтөлсөн 3. Нярайд үзүүлэх тусламж үйлчилгээг удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу үзүүлдэг 4. Нэг хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийн хамралт 90%-иас доошгүй 5. Олон найрлагатай бичил тэжээл хэрэглсэн 6-23 сартай хүүхдийн өсөлтөд судалгаа, дүгнэлт хийдэг 	5, 4, 3, 2, 0
		2.3.Тав хүртэлх насны хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, хяналтыг удирдамж, зааврын дагуу хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Тав хүртэлх насны хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, удирдамж, зааврын дагуу хийж, тэмдэглэл хөтөлдөг 2. 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналтын хувь жил бүр өссөн 3. Тав хүртэлх насны хүүхдэд хийсэн хяналтын бүртгэлтэй 	5, 4, 3, 2, 0
		2.4.Өсвөр насны хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг удирдамж, зааврын дагуу хийдэг, зөвлөгөө өгдөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Өсвөр насны хүүхдэд тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан тусламжийг үзүүлдэг 2. Өсвөр насны хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг стандарт, удирдамж, зааврын дагуу үзүүлдэг, бүртгэл, тэмдэглэл хөтөлдөг 3. Өсвөр насны хүүхдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгдөг 	5, 4, 3, 2, 0
		2.5.Дархлаажуулалтыг зохион байгуулдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Дархлаажуулалт хийх эрүүл ахуйн шаардлага хангасан өрөөтэй 2. Дархлаажуулалтыг товлолын дагуу хийдэг 3. Нөхөн дархлаажуулалтад хамруулсан бүртгэл, судалгаатай 4. Дархлаажуулалтыг зохион байгуулсан тайлан, дүгнэлттэй 5. Дархлаажуулалтын хамралтын хувь улс, аймаг, нийслэлийн дундаж үзүүлэлтийн түвшин, түүнээс дээш байх 	5, 4, 3, 2, 0
3.Мэс заслын тусламж, үйлчилгээ				
1.	Мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлэх зохион байгуулалтыг хийсэн байна.	1.1.Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандарт шаардлагын дагуу мэс заслын тасаг, нэгжийг зохион байгуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Мэс заслын тасаг, нэгжийг зохион байгуулсан, үйл ажиллагаа тогтмолжсон 2. Урсгал зохион байгуулалт нь зөв, эрүүл ахуйн шаардлага хангасан 	5, 4, 3, 2, 0

		1.2.Мэс заслын тусламж, үйлчилгээг зохицуулах журамтай, хэрэгжилтэд хяналт тавьдаг байх	1. Батлагдсан дүрэм, журамтай, мөрддөг 2. Хэрэгжилтэд хяналт тавьсан, авсан арга хэмжээ, үр дүнг тооцсон	5, 4, 3, 2, 0
2.	Эмнэлгийн мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлж, ажлын гүйцэтгэлийг үнэлдэг байна.	2.1.Мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэнтэй байх	1. Тухайн байгууллагын мөрдөх стандартад заасан орон тооны хангалтын хувь 2. Байгууллагын орон тоо баталсан тушаалтай 3. Эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн үнэмлэхтэй 4. Эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	5, 4, 3, 2, 0
		2.2.Эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтанд хамруулж, ур чадварыг дээшлүүлдэг байх	1. Эмнэлгийн мэргэжилтнүүд тасралтгүй сургалтанд хамрагдсан	5, 4, 3, 2, 0
3.	Тусламж, үйлчилгээний технологийг мөрдөж, үнэлгээ дүгнэлт өгч ажилладаг байна.	3.1.Өөрийн байгууллагад хийгдэх мэс засал, мэс ажилбарын батлагдсан жагсаалттай, мөрддөг, байх	1. Мэс засал, мэс ажилбарын батлагдсан жагсаалттай 2. Хийгдсэн мэс заслын бүртгэл, түүний үр дүнд хийсэн дүгнэлт 3. Технологийг эзэмшсэн байдалд хяналт тавьдаг	5, 4, 3, 2, 0
		3.2.Төлөвлөгөөт мэс засал, ажилбарыг хийх хуваарийг урьдчилан баталдаг, бэлтгэлийг хангадаг байх	1. Төлөвлөгөөт мэс засал хийх баталсан хуваарьтай 2. Мэс засал хийх бэлтгэлийг хангасныг батлах хяналтын хуудас хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
